МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТАЛААРХ ИРГЭДИЙН ОЙЛГОЛТ, ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Судалгааны төрөл:	**Санал бодлын судалгаа**
Судалгааны код:	**СТ-25/903**
Огноо:	2025 он 11 сар 25 өдөр

Хянасан:	Г.Гэсэр, ПСХХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга
Судалгаа удирдсан:	П.Түмэнцэцэг, Парламентын хөгжлийн хэлтсийн дарга

Улаанбаатар хот
2025

АГУУЛГЫН ТОВЬЁГ

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ ii
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ ii
СХЕМИЙН ЖАГСААЛТ iii
Удиртгал 1
НЭГдүгээр бүлэг. ТАТВАР ТӨЛӨЛТИЙН ТАЛААРХ БАЙР СУУРЬ, НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ХАМААРАЛ 5
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТАЛААРХ БАЙР СУУРЬ 12
ГУРАВДУГААР БҮЛЭГ.ТӨР БА ИРГЭНИЙ ТАТВАРЫН ХАРИЛЦАН ТОХИРОЛЦОО 18
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ТАТВАР БА ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЛИЛЦОО 21
ТАВДУГААР БҮЛЭГ. БУСДЫН ХАНДЛАГА ТАТВАР ТӨЛӨХ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ НЬ 30
ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ПРОГРЕССИВ ТАТВАРЫГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ БАЙДАЛ 34
ДҮГНЭЛТ 38
САНАЛ 41
НОМ ЗҮЙ 42

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын оршин суугаа газар 3
Хүснэгт 2. Судалгаанд оролцогчдын оршин суугаа дүүрэг, аймаг 3
Хүснэгт 3. Судалгаанд оролцогчдын насны бүлэг, хүйс 3
Хүснэгт 4. Судалгаанд оролцогчдын боловсрол, ажил эрхэлдэг салбар 3
Хүснэгт 5. Судалгаанд оролцогчдын нэг сарын татвар суутгаагүй орлогын хэмжээ 4
Хүснэгт 6. Хүн бүр татвар төлөх ёстой гэдэгтэй санал нэгдэж буй байдал болон бусад хүчин зүйлийн корреляцийн хамаарал 7
Хүснэгт 7. Татварын мөнгийг төрийн үйлчилгээнд зарцуулж буйг дэмжих байдал болон хүн бүр татвар төлөх ёстой гэж үзэх байдал хоорондын харьцуулсан дүн 8
Хүснэгт 8. Зарим хүн татвар төлөхгүй байхад би татвар төлөхгүй байсан нь дээр гэж үзэх байдал болон хүн бүр татвар төлөх ёстой гэж үзэх байдал хоорондын харьцуулсан дүн 9
Хүснэгт 9. Хүн бүр татвар төлөх ёстой эсэх талаар байр суурь болон нөлөөлөгч хүчин зүйлсийн регрессийн шинжилгээ 9
Хүснэгт 10. Та хүн бүр татвар төлөх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрөх үү? (Та хувь хүний орлогын албан татвар төлдөг үү?)..... 14
Хүснэгт 11. Судалгаанд оролцогчдын нэг сарын татвар суутгаагүй орлогын хэмжээ (Ажилладаг салбараар)..... 16
Хүснэгт 12. Цалин, хөдөлмөрийн хөлсний орлогоос ХХОАТ төлдөг хүмүүс төлж буй татварын хэмжээгээ мэддэг эсэх..... 17
Хүснэгт 13. Татварын хэмжээг үнэлж буй байдал болон татвар бууруулж төрийн үйлчилгээг хумьж, хязгаарлах талаар хамаарал 26
Хүснэгт 14. “Зарим хүн татвар төлөхгүй байгаа тул би татвар төлөхгүй байсан нь дээр” гэдэг үгтэй Та санал нийлэх үү? (Та Хувь хүний орлогын албан татвар төлдөг үү?)..... 33

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Та хүн бүр татвар төлөх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрөх үү?..... 5
График 2. Та хүн бүр татвар төлөх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрөх үү? (Насны бүлэг, орлогоор) 6
График 3. Та хувь хүний орлогын албан татвар төлдөг үү?..... 12
График 4. Та хувь хүний орлогын албан татвар төлдөг үү? (Боловсрол, ажилладаг салбар, орлогоор)..... 13
График 5. Та хувь хүний орлогын албан татвар төлдөг бол хэрхэн төлдөг вэ?..... 15
График 6. Та хувь хүний орлогын албан татвар төлдөг бол хэрхэн төлдөг вэ? (Насны бүлэг, ажилладаг салбар, орлогоор) 15
График 7. Орлогод ногдох татварын бодит хэмжээ..... 17
График 8. Таны төлсөн татвар төрийн үйлчилгээг (эрүүл мэнд, боловсрол, цагдаа шүүх, зам харилцаа, халамж гэх мэт) санхүүжүүлэхэд зарцуулагдаж байгааг та дэмжих үү? .18
График 9. “Төр оршихуй дор татвар буй. Татвар буй дор төр оршмуй” гэдэг үгтэй Та санал нийлэх үү?..... 19
График 10. “Төр оршихуй дор татвар буй. Татвар буй дор төр оршмуй” гэдэг үгтэй Та санал нийлэх үү? (Насны бүлэг, боловсрол, орлого) 20
График 11. Төр иргэдийн төлсөн татварыг шударгаар, иргэдэд хэрэгтэй, зөв зүйлд зарцуулж чадаж байгаа эсэхийг Та хэрхэн үнэлэх вэ?..... 21

График 12. Төр иргэдийн төлсөн татварыг шударгаар, иргэдэд хэрэгтэй, зөв зүйлд зарцуулж чадаж байгаа эсэхийг Та хэрхэн үнэлэх вэ? (Боловсрол, ажилладаг салбар, орлогоор) 22
График 13. Хувь хүний сарын орлого 10 сая хүртэлх бол 10%, 10-15 сая бол 15%, 15 саяас дээш бол 20%-ийн татвар төлөхөөр хуульчилсан байдаг. Та тус татварын хувь хэмжээг хэрхэн үнэлэх вэ?.....22
График 14. Хувь хүний сарын орлого 10 сая хүртэлх бол 10%, 10-15 сая бол 15%, 15 саяас дээш бол 20%-ийн татвар төлөхөөр хуульчилсан байдаг. Та тус татварын хувь хэмжээг хэрхэн үнэлэх вэ? (Насны бүлэг, орлогоор).....23
График 15. Нэг сарын орлого болон татварын хувь хэмжээний үнэлгээний регрессийн шинжилгээ.....24
График 16. Та татвар бууруулах бодлогыг дэмждэг бол үүний үр дүнд төрийн үйлчилгээг (цагдаа, боловсрол, эрүүл мэнд, дэд бүтэц гэх мэт) хумьж, хязгаарлахыг зөвшөөрөх үү?) 25
График 17. Та татвар бууруулах бодлогыг дэмждэг бол үүний үр дүнд төрийн үйлчилгээг (цагдаа, боловсрол, эрүүл мэнд, дэд бүтэц гэх мэт) хумьж, хязгаарлахыг зөвшөөрөх үү? (Насны бүлэг, хүйсээр).....25
График 18. Та татвар төлөхгүйгээр төрийн үйлчилгээг (цагдаа, боловсрол, эрүүл мэнд, дэд бүтэц гэх мэт) өөрийн мөнгөөр авахад бэлэн үү?.....26
График 19. Та татвар төлөхгүйгээр төрийн үйлчилгээг (цагдаа, боловсрол, эрүүл мэнд, дэд бүтэц гэх мэт) өөрийн мөнгөөр авахад бэлэн үү? (Насны бүлэг, хүйс, боловсрол, орлогоор) 27
График 20. Та Монгол Улсынхаа хөгжлийг дэлхийн жишигт нийцүүлэхийн тулд татвараа нэмэгдүүлэхийг зөвшөөрөх үү?.....28
График 21. Та Монгол Улсынхаа хөгжлийг дэлхийн жишигт нийцүүлэхийн тулд татвараа нэмэгдүүлэхийг зөвшөөрөх үү? (Оршин суугаа газар, насны бүлэг, орлогоор).....28
График 22. “Зарим хүн татвар төлөхгүй байгаа тул би татвар төлөхгүй байсан нь дээр” гэдэг үгтэй Та санал нийлэх үү? 30
График 23. Таны эргэн тойронд Хувь хүний орлогын албан татвар төлдөггүй хүн байдаг уу? 32
График 24. Яагаад зарим хүн татвар төлдөггүй гэж бодож байна вэ? 33
График 25. “Өндөр орлоготой хүмүүс илүү өндөр хувьтай татвар төлж, нийгмийн өмнө илүү хариуцлага үүрэх нь зүйтэй” гэдэг үгтэй Та санал нийлэх үү? 34
График 26. “Өндөр орлоготой хүмүүс илүү өндөр хувьтай татвар төлж, нийгмийн өмнө илүү хариуцлага үүрэх нь зүйтэй” гэдэг үгтэй Та санал нийлэх үү? (Насны бүлэг, хүйс, боловсрол, ажилладаг салбар, орлогоор).....35
График 27. Хувь хүний орлого өндөр, бага байхаас үл хамааран хүн бүр ижил хувьтай татвар төлөх нь таныхаар шударга уу?.....36
График 28. Хувь хүний орлого өндөр, бага байхаас үл хамааран хүн бүр ижил хувьтай татвар төлөх нь таныхаар шударга уу? (Хүйс, орлогоор) 37

СХЕМИЙН ЖАГСААЛТ

Схем 1. Хүн бүр татвар төлөх ёстой эсэх талаар байр суурь болон нөлөөлөгч хүчин зүйлсийн регрессийн шинжилгээ 11

УДИРТГАЛ

Татвар гэж төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг бүрдүүлэхэд зориулагдсан тухайн татвар төлж буй этгээдээс ямар нэгэн хариу шаардлага тавихгүйгээр гүйцэтгэх үүрэг бүхий мөнгөн төлбөр юм.

Татварын хамгийн эхний зорилго нь төрийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг бий болгоход чиглэж ирсэн бол орчин үед зохицуулах, хянах, нийгмийн гэсэн хандлага руу чиглэж байна. Татварын тусламжтайгаар нийтийн буюу төрийн чиг үүргийг хэрэгжүүлж түүнд шаардагдах зардлыг санхүүжүүлдэг. Тухайлбал,

1. Төрийн албан хаагчдыг цалинжуулах;
2. Ялгаатай байдлыг арилгахын тулд нийгмийн эмзэг хэсэг рүү чиглэсэн төрийн халамжийг санхүүжүүлэх;
3. Боловсрол, эрдэм шинжилгээ судалгаа болон сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааг дэмжих санхүүжүүлэх;
4. Зам харилцаа, цахилгаан түгээх гэх мэт дэд бүтцийг барьж байгуулах, засаж сайжруулах, хадгалах хамгаалах ажиллагааг санхүүжүүлэх;
5. Шүүх, цагдаа, батлан хамгаалах цэрэг армийн зардлыг санхүүжүүлэх гэх мэт (П.Одгэрэл, 2025).

Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт зааснаар 30 төрлийн татвар байдаг.

Өнөөдрийн байдлаар Татварын багц хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд дээрх хуулиудаас Нэмүү өртгийн албан татвар (НӨАТ), Аж ахуй нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ), Хувь хүний орлогын албан татвар (ХХОАТ)-уудад нэмэлт, өөрчлөлт оруулахын хамт Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төсөл боловсруулагдаж байна.

Татварын Ерөнхий хуульд заасан татваруудын ихэнх нь хуулийн этгээд (аж ахуйн нэгж, байгууллага) эсвэл онцгой үйл ажиллагаа эрхэлдэг этгээдүүдэд хамаардаг (жишээлбэл, НӨАТ, гаалийн татвар, газрын төлбөр гэх мэт).

Харин ХХОАТ-ын тухай хууль бусад татварын хуулиас ялгаатай нь татвар төлөгч нь Монгол Улсын иргэн, Монгол улсад 183 хоногоос дээш амьдран сууж байгаа гадаадын иргэд байдгаараа онцлог юм.

ХХОАТ-ын хуулиар цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, үйл ажиллагааны орлого, хөрөнгийн орлого, хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого, шууд бус орлого, бусад буюу урлаг спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал, бичил худалдаа, ажил үйлчилгээний орлого, элдэв төрлийн сугалааны хонжвор гэсэн орлогуудад татвар ногдуулан төлдөг.

Монгол Улсын Сангийн яамнаас хийсэн “Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ”-ээр 2020-2023 онд нийт төвлөрүүлсэн ХХОАТ-ын дүнд цалин хөлс, түүнтэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого болон шууд бус орлогын хувийн жинг харьцуулбал цалин хөлс 76.8%-79.7цалин хөлс 76.8%-79.7%-ийг эзэлж байхад шууд бус орлого 1.0%-1.4%-ийг эзэлж байгаа нь татварын шударга байх зарчимд нийцэхгүй талаар дурдсан.

ХХОАТ-ын талаарх судалгаануудтай танилцахад дийлэнх нь хоёрдогч дата мэдээлэл, экспертийн ярилцлага, иргэдээс ирсэн санал хүсэлтэд тулгуурласан байгаа нь иргэд, олон

нийт татварын талаар ямар ойлголт, хандлага, итгэл үнэмшилтэй болохыг тодорхойлоход учир дутагдалтай байгаа тул тус судалгааг хийсэн болно.

Судалгааны хамрах хүрээ:

Судлах зүйл: Хувь хүний орлогын албан татварын талаарх иргэдийн ойлголт, хандлага

Судалгааны объект:

- Байршил:
  - Улаанбаатар хот: Баянзүрх, Сүхбаатар, Налайх, Хан-Уул дүүрэг
  - Аймаг орон нутаг: Дорнод, Өвөрхангай, Орхон, Сэлэнгэ, Ховд аймаг;
- 18-аас дээш настай, эмэгтэй 55, эрэгтэй 60 хүртэлх насны хүн (Тэтгэвэр, группийн, оюутан, сурагч, малчинд хамаарахгүй);
- Төрийн алба, хувийн байгууллагад ажилладаг болон хувиараа бизнес эрхлэгч.

Судалгааны арга зүй:

№	Судалгааны арга	Зорилго	Үр дүн
1	Асуулгын арга	Төрийн байгууллага, хувийн байгууллага болон хувиараа бизнес эрхлэгчдийн хувь хүний орлогын албан татварын талаарх ойлголт, хандлагыг тодорхойлж тоон үр дүнгээр илэрхийлэх	Давтамж, өгөгдөлд шинжилгээ хийж, тоон дүнгээр илэрхийлэх.
2	Фокус бүлгийн ярилцлага	70-аас доошгүй иргэдийн саналыг сонсох, ярилцлагад оролцож буйд иргэдийн дунд мэтгэлцээн үүсгэн нарийн мэдээлэл олж авах.	Тоон дүнг чанарын судалгаагаар баталгаажуулж, судалж буй асуудлын талаарх ойлголт, шалтгаан, үр дагаврыг тодорхойлох.

Асуулга судалгааны түүвэр:

Судалгааны түүврийн хэмжээг тогтоохдоо социологийн судалгаанд өргөн хэрэглэгддэг статистик болон эмпирик аргуудыг хослуулан хэрэглэсэн болно.

Монгол улсын хэмжээнд хийгддэг суурь судалгаануудаас үзвэл түүврийн дундаж хэмжээ 1100:1 харьцаатай байдаг бол Олон улсын жишигт эх олонлогийг төлөөлж чадахуйц түүврийн хэмжээг 5000:1 гэсэн харьцаатай сонгох нь түгээмэл байдаг.

Түүвэрлэлт хийх онолын үндэс нь хэвийн тархалт байдаг. Энэ нь магадлалд үндэслэдэг. Нэгэнт түүвэрлэлт хийх аргачлал нь магадлалын онол, математик статистикаар боловсруулагдсан байдаг учраас бид тэрхүү аргачлалыг өөрийн судалгааны зорилго, судалгаа хийх бүс нутгийнхаа нийгэм, хүн ам зүйн онцлогт тулгуурлан хэрэглэх боломжтой.

$$n = \frac{t^2 \cdot w \cdot (1-w) \cdot N}{N \cdot \Delta_p^2 + t^2 \cdot w \cdot (1-w)}$$

Үндэсний статистикийн хорооны тайланд 2024 оны 3-р улирлын байдлаар ажил хөдөлмөр эрхлэгчдийн нийт тоо нь 1,355,667 гэж мэдээлсэн (Үндэсний статистикийн хороо, 2024).

Түүврийн хэмжээг ±5 хувийн алдааны магадлалтай, 95 хувийн итгэх түвшинтэйгээр тооцоход 384 гарч байгаа юм.

$$n_0 = \frac{z^2\,p(1-p)}{e^2} = \frac{1.96^2 \times 0.5 \times 0.5}{0.05^2} = \frac{3.8416 \times 0.25}{0.0025} = \frac{0.9604}{0.0025} = 384.16 \;\Rightarrow\; \mathbf{385}$$

$$n = \frac{n_0}{1 + \frac{n_0 - 1}{N}} = \frac{384.16}{1 + \frac{383.16}{692{,}895}} \approx \frac{384.16}{1.00055} \approx \mathbf{384}$$

Бид алдааны магадлалыг бууруулах зорилгоор Улсын хэмжээнд нийт 1,202 хүнийг асуулга судалгаанд хамруулсан.

Асуулга судалгаанд оролцогчдын хүн ам зүйн бүтэц: Түүврийн бүтцийг гаргахдаа үндэсний хэмжээний түүвэр гэж үзэж, Улаанбаатар хотын 4 дүүрэг, аймаг орон нутгийн 5 бүсээс тус бүр нэг аймгийг сонгож, нас, хүйс, боловсрол, ажил эрхэлдэг салбар, орлогыг харгалзсан.

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын оршин суугаа газар

Оршин суугаа газар	Тоо	Хувь
Аймаг, орон нутаг	646	54%
Улаанбаатар хот	556	46%
Нийт	**1202**	**100%**

Хүснэгт 2. Судалгаанд оролцогчдын оршин суугаа дүүрэг, аймаг

Дүүрэг	Тоо	Хувь	Аймаг	Тоо	Хувь
Баянзүрх	271	49%	Дорнод	120	19%
Налайх	34	6%	Сэлэнгэ	125	19%
Сүхбаатар	86	15%	Орхон	105	16%
Хан-Уул	165	30%	Өвөрхангай	173	27%
Нийт	**556**	**100%**	Ховд	123	19%
			Нийт	**646**	**100%**

Хүснэгт 3. Судалгаанд оролцогчдын насны бүлэг, хүйс

Насны бүлэг	Тоо	Хувь	Хүйс	Тоо	Хувь
18-24 нас	103	9%	Эрэгтэй	524	44%
25-29 нас	149	12%	Эмэгтэй	678	56%
30-39 нас	401	33%	**Нийт**	**1202**	**100%**
40-49 нас	340	28%			
50-аас дээш нас	209	17%			
Нийт	**1,202**	**100%**			

Хүснэгт 4. Судалгаанд оролцогчдын боловсрол, ажил эрхэлдэг салбар

Боловсрол	Тоо	Хувь	Ажилладаг салбар	Тоо	Хувь
Байхгүй / Бага сургууль	13	1%	Төрийн алба	202	17%
Бүрэн бус дунд	81	7%	Хувийн байгууллага	610	51%
Бүрэн дунд	428	36%	Хувиараа бизнес эрхлэгч	390	32%
Тусгай дунд (мэргэжлийн боловсрол)	77	6%	**Нийт**	**1,202**	**100%**
Дээд/Бакалавр	552	46%			
Магистр болон түүнээс дээш	51	4%			
Нийт	**1,202**	**100%**			

Хүснэгт 5. Судалгаанд оролцогчдын нэг сарын татвар суутгаагүй орлогын хэмжээ

Орлого	Тоо	Хувь	Орлого	Тоо	Хувь
800,000 төгрөг хүртэлх	86	7%	3,300,001-3,800,000 төгрөг	37	3%
800,001-1,300,000 төгрөг	258	21%	3,800,001-4,300,000 төгрөг	32	3%
1,300,001-1,800,000 төгрөг	268	22%	4,300,001-4,800,000 төгрөг	10	1%
1,800,001-2,300,000 төгрөг	187	16%	4,800,001-ээс дээш	86	7%
2,300,001-2,800,000 төгрөг	108	9%	**Нийт**	**1202**	**100%**
2,800,001-3,300,000 төгрөг	130	11%			

***Фокус бүлгийн ярилцлагын түүвэр**:*

Фокус бүлгийн ярилцлагыг Ховд, Орхон, Дорнод, Сэлэнгэ аймгийн төв, Сүхбаатар, Баянзүрх, Хан-Уул дүүрэгт тус бүр нэг удаа, нийт 7 удаа хийж, 70 хүнийг хамруулсан.

Нэг удаагийн ярилцлагад 10 хүнийг хамруулах бөгөөд нас, хүйс, ажил эрхлэлт зэргийг харгалзаж, түүврийн төлөөлөх чадварт анхаарч ажилласан.

Судалгааны мэдээлэл цуглуулах арга: Судалгааг нийгмийн эмпирик судалгааны тоон болон чанарын судалгааны аргыг ашиглан хийнэ. Тоонд судалгааны хүрээнд асуулгын (анкетын) нүүр тулсан ярилцлагын аргыг (Face-to-Face-interview) ашиглах бол, чанарын судалгааны хүрээнд фокус бүлгийн хэлэлцүүлгийн (focus group discussion) аргыг ашигласан.

Судалгааны мэдээлэлд боловсруулалт хийсэн арга:

Тоон судалгааны үр дүнг судалгааны боловсруулалтын SPSS 26, AMOS программ ашиглаж хийсэн. Зарим хамаарлын шинжилгээг хийхдээ хамаарах болон үл хамаарах хувьсагчийн бүлгийг тодорхойлж, 1-ээс 5 хүртэлх онооны нийлбэр үр дүнд үндэслэн 0-оос 1 хүртэлх онооны интервалд шилжүүлж, регрессийн шинжилгээ хийсэн.

Фокус бүлгийн ярилцлагын бичлэгийг бичгээр буулгаж, матрицад хөрвүүлэн, үр дүнд шинжилгээ хийсэн болно.

Судалгааны мэдээлэл цуглуулсан хугацаа: 2025.10.13-2025.10.29

Судалгааны мэдээлэл цуглуулсан байгууллага: Вай Ин Сайт ХХК

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТАТВАР ТӨЛӨЛТИЙН ТАЛААРХ БАЙР СУУРЬ, НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ХАМААРАЛ

Татварын талаар ямар ойлголттой байгааг фокус бүлгийн ярилцлагаар тодруулахад Монгол Улсад ажиллаж, амьдарч байгаа хүн бүр татвар төлдөг. Татвар төлөх үүргээ хүн бүр биелүүлснээр төрийн үйлчилгээг үнэгүй, зарим тохиолдолд хөнгөлөлттэй хэлбэрээр авах нөхцөлийг бүрдүүлэх, авлига албан тушаалын хэргээс урьдчилан сэргийлэх давуу талтай ч, зарим хүн татвараа төлдөггүй нь татвар төлөлтийн эрх тэгш байдал буюу шударга байдлыг алдагдуулдаг. Мөн татварын хувь хэмжээ өндөр, давхардсан байдаг нь иргэд, ААН-үүдэд дарамт учруулдаг гэсэн байр суурийг илэрхийлсэн байна.

Мөн Татвар авахдаа цалингаас суутгачихдаг тул хууль ёсоор улсад өгөх ёстой хураамж гэж ойлгогддог.

Олон төрлийн татвар иргэд, ААН-үүд өгдөг ч ХХОАТ, НӨАТ, Гаалийн болон ААН-ийн гэх зэрэг олон албан татвар байдаг гэх ойлголт хамгийн түгээмэл байна.


ХХОАТ-ын талаарх ойлголт, бусад татвараас юугаараа ялгаатай болохыг тодруулахад, Монгол Улсад ажиллаж, ААН эрхэлж байгаа хүн бүр орлогоосоо татвар төлдөг гэж тайлбарлаж байгаа ч ХХОАТ, ААНОАТ-ын ялгааг төдийлөн мэдэхгүй, хольж ойлгож байна. Өөрөөр хэлбэл, ямар нэг байдлаар хүн болон байгууллагын дансанд орлого ороход шууд татвар хэлбэрээр таталт хийж байгааг татвар гэж ерөнхийд нь ойлгож байна.

ХХОАТ-ын хувь хэмжээг хэрхэн тооцдог, орлогын ялгаатай байдлаас үүдсэн шаталсан татвар ноогдуулдаг талаар мэдэхгүй, татварын мөнгөний зарцуулалт ил тод байдаггүй учраас юунд зарцуулагддаг болохыг мэддэггүй гэж судалгаанд оролцогчдын зүгээс хариулсан.

“Хүн бүр татвар төлөх ёстой” гэдгийг хүлээн зөвшөөрөх эсэхийг тодруулахад дундаж үнэлгээ 3.7 буюу хүн бүр татвар төлөхийг зөв гэж үзэх хандлагатай байна. Тодруулбал, судалгаанд оролцогчдын 65% буюу ойролцоогоор 10 хүн тутмын 7 нь хүн бүр татвар төлөх ёстой гэдгийг зөвшөөрч байгаа бол 19% буюу 10 хүн тутмын 2 нь зөвшөөрөхгүй гэж хариулжээ.

График 1. Та хүн бүр татвар төлөх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрөх үү?

Дундаж: 3.7




Тайлбар: *Огт зөвшөөрөхгүй бол 1, мэдээж зөвшөөрөх бол 5, 1-ээс 5 оноогоор үнэлсэн.*

“Хүн бүр татвар төлөх ёстой” гэдэг үгийг хүлээн зөвшөөрөх эсэхийг тодруулж, судалгаанд оролцогчдын хүн ам зүйн үзүүлэлтээр ялгаа байгаа эсэхийг тодруулахад насны бүлэг, орлогоор ($p<0.05$) ялгаатай үр дүн гарсан.

График 2-оос харвал, хүн бүр татвар төлөх ёстой” гэдэг үгийг зөвшөөрч буй байдал нас нэмэгдэх болон нэг сарын орлогын хэмжээ нэмэгдэхтэй зэрэгцэн өсөж байна. Тодруулбал, 40-өөс дээш насныхан болон сарын орлого нь 2,300,000-аас дээш орлоготой хүмүүс “хүн бүр татвар төлөх ёстой” гэдгийг зөвшөөрөх байдал нэмэгдэж байгаа бол зөвшөөрөхгүй байх хандлага 18-24 насныхан болон сарын 1,800,000 төгрөгийн орлоготой хүмүүсийн дунд жин дарж байна.

График 2. Та хүн бүр татвар төлөх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрөх үү? (Насны бүлэг, орлогоор)

Дундаж:



Тайлбар: *Огт зөвшөөрөхгүй бол 1, мэдээж зөвшөөрөх бол 5, 1-ээс 5 оноогоор үнэлсэн.*

Фокус бүлгийн ярилцлагын хүрээнд “Хүн бүр татвар төлөх ёстой” гэдгийг хүлээн зөвшөөрөх эсэхийг тодруулахад ярилцлагад оролцогчдын 65% нь зөвшөөрнө гэж хариулсан нь тоон судалгааны дүнг баталгаажуулсан. Ийнхүү хариулж буй шалтгааныг тодруулахад татвар төлөх нь иргэн бүрийн хуулиар хүлээсэн үүрэг тул орлого олж буй хүн бүр татвар төлөх нь шударга зарчим гэж үзэхийн зэрэгцээ татвар бол улсын төсвийг гол эх үүсвэр гэж иргэд тайлбарлаж байна.

Тодруулбал, зам, сургууль, эмнэлэг, нийгмийн халамж зэрэг төрийн үйлчилгээ нь татварын мөнгөөр бий болдог бөгөөд төсөв бүрдэж байж улс хөгждөг тул иргэн бүр хуулийн дагуу үүргээ биелүүлэх хэлбэрээр улсдаа хувь нэмрээ оруулах ёстой гэх хандлагатай байна.

Харин “хүн бүр татвар төлөх ёстой” гэдгийг хүлээн зөвшөөрөх эсэхээ мэдэхгүй, эргэлзсэн хүмүүсийн хувьд татварын талаарх мэдээлэл дутмаг, татварын мөнгөний зарцуулалт ил тод

биш, үр дүн нь ойлгомжгүй, зарим тохиолдолд татварын хэмжээ өндөр санагддаг болохоо илэрхийлсэн.

Тэгвэл тус асуултад зөвшөөрөхгүй гэж хариулсан шалтгаан нь татварын зарцуулалт ил тод биш, үр ашиггүй, татварын тогтолцоог шударга бус, ажил хийж, амьжиргаагаа залгуулахад татвар дарамт болдог гэж үзэх байдал байна.

Тодруулбал, төлсөн татварын мөнгөний зарцуулалт ойлгомжгүй, төсвийн мөнгийг үр ашиггүй зүйлд зарцуулдаг, бага орлоготой хүмүүсээс татвар өндөр авдаг хэр нь өндөр орлоготой, бизнес эрхлэгч нар зарим тохиолдолд татвар төлдөггүй, цалингийн орлого нь амьжиргаанд нь хүрэлцэхгүй байхад татвар авч, амьдралд нь дарамт болдог гэж судалгаанд оролцогчид тайлбарласан.

“Хүн бүр татвар төлөх ёстой” гэж үзэх хандлага татварын мөнгийг төрийн үйлчилгээнд зарцуулж буйг дэмжих хандлага, бусад хүн татвар төлөхгүй бол өөрөө ч төлөхгүй байж болно гэх нийгмийн орчны нөлөөллийн хандлага, татварын мөнгийг төр үр ашигтай зүйлд зарцуулж буй эсэх талаарх үнэлгээ, прогрессив татварын бодлоготой санал нийлж байгаа эсэх хандлагатай статистикийн хувьд ач холбогдол бүхий хамааралтай байна.

Хамаарлын зэргийг харвал татварын мөнгийг төрийн үйлчилгээнд зарцуулж буйг дэмжих хандлага нэмэгдэх тусам хүн бүр татвар төлөх ёстой гэх хандлага нэмэгдэх эерэг хамаарал хамгийн өндөр.

Тэгвэл татварын мөнгийг төр үр ашигтай зүйлд зарцуулж буй эсэх талаарх үнэлгээ, прогрессив татварын бодлоготой санал нийлж байгаа эсэх нь хүн бүр бүр татвар төлөх ёстой гэх хандлагатай сул эерэг хамааралтай байна.

Хүснэгт 6. Хүн бүр татвар төлөх ёстой гэдэгтэй санал нэгдэж буй байдал болон бусад хүчин зүйлийн корреляцийн хамаарал

Correlations					
	Та хүн бүр татвар төлөх ёстой гэдгийг зөвшөөрдөг үү?	Таны төлсөн татвар төрийн үйлчилгээг (эрүүл мэнд, боловсрол, цагдаа шүүх, зам харилцаа, халамж гэх мэт) санхүүжүүлэхэд зарцуулагдаж байгааг Та дэмжих үү?	Зарим хүн татвар төлөхгүй байгаа тул би татвар төлөхгүй байсан нь дээр” гэдэг үгтэй Та санал нийлэх үү?	Төр иргэдийн төлсөн татварыг шударгаар, иргэдэд хэрэгтэй, зөв зүйлд зарцуулж чадаж байгаа эсэхийг Та хэрхэн үнэлэх вэ?	Өндөр орлоготой хүмүүс илүү өндөр хувьтай татвар төлж, нийгмийн өмнө илүү хариуцлага үүрэх нь зүйтэй” гэдэг үгтэй Та санал нийлэх үү?
Та хүн бүр татвар төлөх ёстой гэдгийг зөвшөөрдөг үү?					
Таны төлсөн татвар төрийн үйлчилгээг (эрүүл мэнд, боловсрол, цагдаа шүүх, зам харилцаа, халамж гэх мэт) санхүүжүүлэхэд зарцуулагдаж байгааг Та дэмжих үү?	.327**				

“Зарим хүн татвар төлөхгүй байгаа тул би татвар төлөхгүй байсан нь дээр” гэдэг үгтэй Та санал нийлэх үү?	-.228**	-.177**			
Төр иргэдийн төлсөн татварыг шударгаар, иргэдэд хэрэгтэй, зөв зүйлд зарцуулж чадаж байгаа эсэхийг Та хэрхэн үнэлэх вэ?	.091**	.156**	-.071*		
“Өндөр орлоготой хүмүүс илүү өндөр хувьтай татвар төлж, нийгмийн өмнө илүү хариуцлага үүрэх нь зүйтэй” гэдэг үгтэй Та санал нийлэх үү?	.115**	.067*	0.019	.071*	
**. Correlation is significant at the 0.01 level (2-tailed).					
*. Correlation is significant at the 0.05 level (2-tailed).					

Татварын мөнгийг төрийн үйлчилгээнд зарцуулж буйг дэмжих хандлага нэмэгдэх тусам хүн бүр татвар төлөх ёстой гэх хандлага нэмэгдэх эерэг хамаарал хамгийн өндөр байгаа нь Хүснэгт 6 дахь үр дүнгээр баталгаажсан.

Тодруулбал, татварын мөнгийг төрийн үйлчилгээнд зарцуулж буйг зөвшөөрч буй хүмүүсийн 50% нь (Зөвшөөрч буй хүмүүсийн дүнг 100% гэж үзвэл 73%) хүн бүр татвар төлөх ёстой гэж үзэж байна.

Хүснэгт 7. Татварын мөнгийг төрийн үйлчилгээнд зарцуулж буйг дэмжих байдал болон хүн бүр татвар төлөх ёстой гэж үзэх байдал хоорондын харьцуулсан дүн

Та хүн бүр татвар төлөх ёстой гэдгийг зөвшөөрдөг үү?	**Таны төлсөн татвар төрийн үйлчилгээг (эрүүл мэнд, боловсрол, цагдаа шүүх, зам харилцаа, халамж гэх мэт) санхүүжүүлэхэд зарцуулагдаж байгааг Та дэмжих үү?**				
		Дэмжинэ	**Магадгүй**	**Дэмжихгүй**	**Нийт**
	Зөвшөөрнө	**50%**	10%	6%	**65%**
	Магадгүй	10%	4%	2%	**16%**
	Зөвшөөрөхгүй	8%	4%	7%	**19%**
	Нийт	**68%**	**18%**	**14%**	**100%**

Хүн бүр татвар төлөх ёстой гэдэгтэй санал нийлэх тусам зарим хүн татвар төлөхгүй байгаа тул би татвар төлөхгүй байсан дээр гэдэгтэй санал нийлэхгүй байна гэж үзэх байдал өссөн сөрөг хамааралтай гэсэн дүн Хүснэгт 6-аар гарсан.

Тодруулбал, “Зарим хүн татвар төлөхгүй байхад би татвар төлөхгүй байсан нь дээр” гэж үздэг хүмүүсийн 40% (Санал нийлэхгүй хүмүүсийн дүнг 100% гэж үзвэл 74%) хүн бүр татвар төлөх ёстой гэж үзэж байна.

Хүснэгт 8. Зарим хүн татвар төлөхгүй байхад би татвар төлөхгүй байсан нь дээр гэж үзэх байдал болон хүн бүр татвар төлөх ёстой гэж үзэх байдал хоорондын харьцуулсан дүн

Та хүн бүр татвар төлөх ёстой гэдгийг зөвшөөрдөг үү?	“Зарим хүн татвар төлөхгүй байгаа тул би татвар төлөхгүй байсан нь дээр” гэдэг үгтэй Та санал нийлэх үү?				
		Санал нийлнэ	**Магадгүй**	**Санал нийлэхгүй**	**Нийт**
	Зөвшөөрнө	13%	12%	**40%**	**65%**
	Магадгүй	3%	6%	7%	**16%**
	Зөвшөөрөхгүй	7%	5%	8%	**19%**
	Нийт	**22%**	**23%**	**55%**	**100%**

Хүснэгт 9. Хүн бүр татвар төлөх ёстой эсэх талаар байр суурь болон нөлөөлөгч хүчин зүйлсийн регрессийн шинжилгээ

Coefficients[a]

Model		Unstandardized Coefficients		Standardized Coefficients	t	Sig.
		B	Std. Error	Beta		
1	(Constant)	.459	.029		15.947	.000
	Татварын мөнгийг төрийн үйлчилгээнд зарцуулахыг дэмжих байдал	.330	.031	.296	10.785	.000
	Зарим хүн татвар төлөхгүй байхад би татвар төлөхгүй байж болно гэж үзэх байдал	-.176	.029	-.164	-6.049	.000
	Татварын мөнгийг төр үр ашигтай зүйлд зарцуулж буй байдал	.066	.038	.047	1.735	.083
	Прогрессив татварыг дэмжих байдал	.095	.025	.103	3.838	.000

a. Dependent Variable: “Хүн бүр татвар төлөх ёстой” эсэх талаар байр суурь

Y = *Constant + (B1 * X1+e2) + (B2 * X2+e3) + (B3 * X3+e4) + (B3 * X4+e5)*

- ***Y =*** *Хүн бүр татвар төлөх ёстой гэж үзэх хандлага*
- ***Constant =*** *Бүх хувьсагчийн утга = 0 байх тохиолдлын суурь үнэлгээ*
- $B_1 \ldots B_n$ = *Тухайн хувьсагчийн оноо 1 оноогоор нэмэгдэхэд нэмэгдэх нэгж*
- $X_1 \ldots X_n$ = *Тухайн хувьсагчийн дундаж оноо*
- ***SE =*** *Стандарт алдаа*

Хүн бүр татвар төлөх ёстой гэж үзэх хандлага **=** 0.459**+ (0.330 * X+0.69) + (-0.176* X-0.37) + (0.95* X+0.53)**

Y (constant)	X буюу хамаарах хувьсагчид	**B**	**SE**
0.459	Татварын мөнгийг төрийн үйлчилгээнд зарцуулахыг дэмжих байдал	0.33	**0.69**
	Зарим хүн татвар төлөхгүй байхад би татвар төлөхгүй байж болно гэж үзэх байдал	-0.176	**0.37**
	Татварын мөнгийг төр үр ашигтай зүйлд зарцуулж буй байдал	0.066	**0.18**
	Прогрессив татварыг дэмжих байдал	0.095	**0.53**

Дээрх 4 хүчин зүйл огт нөлөөлөөгүй үед Хүн бүр татвар төлөх ёстой гэдэгтэй санал нийлэх байдал 0.459 байна.

Хүн бүр татвар төлөх ёстой гэж үзэх хандлагад дээрх 4 хүчин зүйлийн 3 нь статистик ач холбогдол бүхий нөлөө үзүүлж байна. Хүн бүр татвар төлөх ёстой гэх хандлагыг олон хүчин зүйлийн регрессийн тэгштгэлээр бодохдоо хувьсагч тус бүрийг 5 онооны системээр үнэлсэн (1 бол огт зөвшөөрөхгүй, 5 бол мэдээж зөвшөөрнө, 1-ээс 5 оноо өгсөн) болно.


Регрессийн тэгштгэлийг харвал, татварын мөнгийг төрийн үйлчилгээнд зарцуулахыг дэмжих байдал нэг нэгжээр нэмэгдэхэд Хүн бүр татвар төлөх ёстой гэдэгтэй санал нийлэх байдал 0.330 нэгжээр нэмэгдэнэ.

Зарим хүн татвар төлөхгүй байхад би татвар төлөхгүй байж болно гэж үзэх байдал нэг нэгжээр нэмэгдэхэд Хүн бүр татвар төлөх ёстой гэдэгтэй санал нийлэх байдал 0.176 нэгжээр буурна.

Прогрессив татварыг дэмжих байдал нэг нэгжээр нэмэгдэхэд Хүн бүр татвар төлөх ёстой гэдэгтэй санал нийлэх байдал 0.095 нэгжээр нэмэгдэнэ.

Иймд “Хүн бүр татвар төлөх ёстой гэж үзэх хандлагад” татварын мөнгийг төрийн үйлчилгээнд зарцуулахыг дэмжих байдал болон прогрессив татварыг дэмжих байдал нь эерэг нөлөө, зарим хүн татвар төлөхгүй байхад би татвар төлөхгүй байж болно гэж үзэх байдал нь сөрөг нөлөө үзүүлдэг. Харин татварын мөнгийг төр үр ашигтай зүйлд зарцуулж буй байдлын үнэлгээ нөлөө үзүүлэхгүй байна.

Схем 1. Хүн бүр татвар төлөх ёстой эсэх талаар байр суурь болон нөлөөлөгч хүчин зүйлсийн регрессийн шинжилгээ



ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТАЛААРХ БАЙР СУУРЬ

Хувь хүний орлогын албан татвар төлөлтийн дундаж үнэлгээ 4.2 буюу судалгаанд оролцогчдын олонх нь татвар төлдөг байна. Тодруулбал, судалгаанд оролцогчдын 78% буюу ойролцоогоор 10 хүн тутмын 8 нь ХХОАТ төлдөг, 7% нь хамаа төлдөг, 15% буюу 10 хүн тутмын 1-2 нь төлдөггүй гэж хариулсан.

График 3. Та хувь хүний орлогын албан татвар төлдөг үү?

Дундаж: 4.2



Тайлбар: *Огт төлдөггүй бол 1, байнга төлдөг бол 5, 1-ээс 5 оноогоор үнэлсэн.*

ХХОАТ төлдөг эсэх талаарх хариулт нь судалгаанд оролцогчдын хүн ам зүйн үзүүлэлтийн хувьд ялгаа байгаа эсэхийг тодруулахад боловсрол, ажилладаг салбар, орлогын хувьд ($p<0.05$) ялгаатай үр дүн гарсан.


Судалгааны үр дүнг харвал, боловсрол өндөр, тогтвортой байгууллагад ажилладаг, дундаас дээш орлоготой иргэдийн дунд татвар төлөлт илүү өндөр байна. Тодруулбал,

Дээд/бакалавраас дээш боловсролтой хүмүүс ХХОАТ төлөх байдал хамгийн өндөр байгаа бол бага сургууль төгссөн/боловсролгүй, бүрэн бус дунд боловсролтой хүмүүсийн татвар төлөлт хамгийн бага байна. Энэ нь боловсролын түвшин өсөх тутам ХХОАТ төлөлт өндөр байдгийг харуулж байна.

Ажилладаг салбараас харвал төрийн албанд ажиллагсад 100% ХХОАТ төлдөг, харин хувийн байгууллагад ажиллагсдын 82%, хувиараа бизнес эрхлэгчдийн 58% нь татвараа төлж байна. Энэ нь төрийн албанд ажилладаг бол цалингаасаа шууд суутгуулах байдлаар ХХОАТ төлдөг, хувийн байгууллагад ажилладаг бол цалингаасаа суутгуулах хэлбэрээр дийлэнх нь татвараа төлдөг ч зарим тохиолдолд татвар төлөхгүй байх тохиолдол гардаг, харин хувиараа бизнес эрхлэгчид шууд татварын таталт хийлгэх нөхцөл хязгаарлагдмал тул ХХОАТ төлөхгүй байх тохиолдол хамгийн өндөр байдгийг харуулж байна.

Нийт судалгаанд оролцогчдын сарын дундаж орлого 2,468,705 төгрөг гарсан. Судалгаанд оролцогчдын сарын дундаж орлогоор татвар төлөлтийн байдлыг харьцуулан харвал дунжаас дээш буюу 2,300,001-4,800,000 төгрөгийн орлоготой хүмүүсийн ХХОАТ-ын төлөлт хамгийн өндөр байна. Харин 800,000 төгрөг хүртэлх сарын орлоготой хүмүүс болон 4,800,000-аас дээш орлоготой хүмүүсийн татвар төлөлт хамгийн бага байна.

График 4. Та хувь хүний орлогын албан татвар төлдөг үү? (Боловсрол, ажилладаг салбар, орлогоор)



Тайлбар: Огт төлдөггүй бол 1, байнга төлдөг бол 5, 1-ээс 5 оноогоор үнэлсэн.

ХХОАТ төлдөг хүмүүсийн 54% нь (ХХОАТ төлдөг хүмүүсийг 100% гэж үзвэл 70%) “хүн бүр татвар төлөх ёстой” гэдгийг хүлээн зөвшөөрдөг ч 12% нь (ХХОАТ төлдөг хүмүүсийг 100% гэж үзвэл 16%) хүлээн зөвшөөрөхгүй байна. Энэ нь ХХОАТ төлдөг хүмүүс хүн бүр татвар төлөх ёстой гэж үзэх хандлага өндөр ч зарим тохиолдолд хүн бүр татвар төлөх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрөхгүй, татварын бодлогод итгэх итгэл сул байдгийг харуулж байна.

Мөн ХХОАТ төлдөггүй хүмүүсийн 7% (ХХОАТ төлдөггүй хүмүүсийг 100% гэж үзвэл 46%) буюу 2 хүн тутмын нэг нь хүн бүр татвар төлөх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа нь татвар төлдөггүй ч татварын үүргийг хүлээн зөвшөөрөх байдлыг харуулж байна. Нөгөө талаар ХХОАТ төлдөггүй хүмүүсийн 5% (ХХОАТ төлдөггүй хүмүүсийг 100% гэж үзвэл 33%) буюу 3 хүн тутмын нэг нь хүн бүр татвар төлөх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрөхгүй байх хандлага өндөр байгааг харуулж байна.

Дээрхээс дүгнэвэл ХХОАТ төлдөг хүмүүс болон ХХОАТ төлдөггүй хүмүүс аль аль нь хүн бүр татвар төлөх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрөх байдал өндөр байна. Гэхдээ ХХОАТ төлдөггүй хүмүүс татвар төлдөггүй хүмүүстэй харьцуулахад “хүн бүр татвар төлөх ёстой” гэдгийг хүлээн зөвшөөрөхгүй байдал өндөр байгааг анхаарвал зохино.

Хүснэгт 10. Та хүн бүр татвар төлөх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрөх үү? (Та хувь хүний орлогын албан татвар төлдөг үү?)

		Та хувь хүний орлогын албан татвар төлдөг үү?			
Та хүн бүр татвар төлөх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрөх үү?		**Төлдөг**	**Хааяа төлдөг**	**Төлдөггүй**	**Нийт**
	Зөвшөөрнө	**54%**	**4%**	**7%**	**65%**
	Магадгүй	11%	1%	3%	**16%**
	Зөршөөрөхгүй	**12%**	2%	5%	**19%**
	Нийт	**78%**	**7%**	**15%**	**100%**

График 4-т харуулсанчлан хувиараа бизнес эрхлэгч 2 хүн тутмын нэг нь ХХОАТ төлдөг бол 29% нь төлдөггүй, 13% нь хааяа төлдөг. Эдгээр хүмүүс ХХОАТ төлөх тохиолдолд өөрөө үйл ажиллагааны орлогоо тодорхойлж, тайлагнаж, татвар төлдөг хүмүүс юм.


ХХОАТ-ыг цалин, хөдөлмөрийн хөлсний орлогоосоо шууд татуулах хэлбэрээр төлдөг хүмүүс зарим хүн татвар төлөхгүй байгаа байдлыг шударга бус гэж үзэж байна. Фокус бүлгийн ярилцлагаар тус нөхцөл байдлыг хэрхэн харж буйг тодруулахад Монголд ХХОАТ-ыг автоматаар суутгуулдаггүй иргэдийн хувьд орлогоо сайн дурааараа тайлагнах хувь бага байдаг бөгөөд үүний гол шалтгаан нь татварын тогтолцоонд итгэл сул, хяналтын систем хангалтгүй, татварын боловсрол дутмаг байдал гэж харж байна.

Тодруулбал, хувиараа бизнес эрхлэгч нар (тогтмол орлогогүй, бэлэн мөнгөөр орлого олдог, үйлчилгээ, худалдааны салбарт ажилладаг, ААН эрхэлдэггүй) ихэвчлэн өөрөө үйл ажиллагааны орлогоо тодорхойлж, тайлагнадаггүй бөгөөд татвараас зайлсхийдэг. Үүний шалтгаан нь:

- Хяналтын систем хангалтгүй: татварын байгууллага болон хамаарах төрийн байгууллагын хяналт сул, хянаж, шалгадаггүй тул орлогоо тайлагнаж, татвар төлдөггүй.
- Татварын боловсрол дутмаг: хүмүүс татварын талаарх мэдээлэлгүйдээ биш, сайн дураар татвар төлөх талаар мэдээллийг сонирхдоггүй, тайлагная гэсэн ч хэрхэн тайлагнах тухайгаа мэддэггүй.
- Татварын шударга бус байдал: Зарим нь хөдөлмөрийн хөлсний орлогоосоо шууд суутгуулж татвар төлж байхад зарим нь төлдөггүй, дундаж орлоготой хүмүүст татварын дарамт өндөр тусдаг нь шударга бус мэдрэмж өгдөг зэрэг асуудлууд байна.

Судалгаанд оролцогчдын 78% нь ХХОАТ төлдөг. Тус дүнг 100% гэж тооцвол 74% буюу ойролцоогоор 10 хүн тутмын 7 нь ХХОАТ-ыг цалин, хөдөлмөрийн хөлсний орлогоос шууд суутгуулдаг бол 24% буюу ойролцоогоор 10 хүн тутмын 2 нь өөрөө үйл ажиллагааны орлогоо тодорхойлж, тайлагнаж, татвар төлдөг байна.


График 5. Та хувь хүний орлогын албан татвар төлдөг бол хэрхэн төлдөг вэ?



ХХОАТ төлдөг хэлбэр судалгаанд оролцогчдын хүн ам зүйн үзүүлэлтийн хувьд ялгаа байгаа эсэхийг тодруулахад насны бүлэг, ажилладаг салбар, орлогын хувьд ($p<0.05$) ялгаатай үр дүн гарсан.

Дийлэнх тохиолдолд иргэд ХХОАТ төлөхдөө цалин, хөдөлмөрийн хөлсний орлогоос шууд суулгуулдаг. Ялгаатай байдлыг харвал 18-29 настай залуучууд, төрийн алба болон хувийн байгууллагад ажилладаг, 1,300,000-2,800,000 төгрөгийн цалинтай хүмүүс цалин, хөдөлмөрийн хөлсний орлогоос шууд суутгуулах хэлбэрээр ХХОАТ төлдөг бол, 30-аас дээш насны, хувийн бизнес эрхэлдэг, 4,800,000-аас дээш орлоготой хүмүүс өөрөө үйл ажиллагааны орлогоо тодорхойлж, тайлагнаж, татвар төлдөг байна.

График 6. Та хувь хүний орлогын албан татвар төлдөг бол хэрхэн төлдөг вэ? (Насны бүлэг, ажилладаг салбар, орлогоор)



ХХОАТ төлдөг, төлдөггүй байх шалтгааныг фокус бүлгийн ярилцлагын хүрээнд тодруулахад, дийлэнх ХХОАТ татвар төлдөг хүмүүс цалингаасаа шууд татуулах хэлбэрээр төлдөг. Харин сайн дурын үндсэн дээр орлогоо мэдүүлж, ХХОАТ төлдөг хүмүүс нэгдүгээрт, хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх, хоёрдугаарт аливаа зээлд хамрагдах, бизнесийн үйл ажиллагаагаа тэлэх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, төрийн үйлчилгээ авахын тулд татвар төлдөг байна.

Харин хувираа бизнес эрхлэхэд бүхий л үйл ажиллагаа болон зардал хувь хүний нуруун дээр байдаг гэх шалтгаанаар ХХОАТ төлдөггүй тохиолдол байна. Мөн зарим үед хуулийн хүрээнд татвараас чөлөөлөгддөг үйл ажиллагаа явуулдаг нь татвараас чөлөөлөгдөх нөхцөлийг бүрдүүлдэг аж.

ХХОАТ-ын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар, 120 000 001-180 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 12 000 000 төгрөг дээр 120 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 15 хувиар, 180 000 000 төгрөгөөс дээш албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 21 000 000 төгрөг дээр 180 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 20 хувиар нэмж тооцон албан татвар ногдуулна” гэж заасан байдаг.

Судалгаанд оролцогчдын нэг сарын татвар суутгаагүй дундаж орлого 2,468,705 байгаа бол хамгийн бага нь 150,000 төгрөг, хамгийн өндөр нь 42,000,000 төгрөг байна


Ажилладаг салбараар харвал, төрийн албан хаагчдын орлого харьцангуй тогтвортой, хамгийн бага орлого харьцангуй өндөр боловч дээд орлого нь 4 сая төгрөгөөс хэтрэхгүй байна. Харин хувийн байгууллагад ажиллагсдын орлогын ялгаа маш их буюу тухайн байгууллага, албан тушаал, мэргэжлийн онцлогоос шалтгаалж орлого ихээхэн хэлбэлзэж байна. Тэгвэл хувираа бизнес эрхлэгчдийн орлого хамгийн өндөр боловч хэлбэлзэл маш ихтэй байна.

Хүснэгт 11. Судалгаанд оролцогчдын нэг сарын татвар суутгаагүй орлогын хэмжээ (Ажилладаг салбараар)

	Mean	**Minimum**	**Maximum**
Төрийн алба	1,806,805	650,000	4,000,000
Хувийн байгууллага	2,035,410	150,000	30,000,000
Хувираа бизнес эрхлэгч	3,489,254	150,000	42,000,000
Дундаж	**2,468,705**	**150,000**	**42,000,000**

Судалгаанд оролцогчдын нэг сарын татвар суутгаагүй орлогын хэмжээнд ХХОАТ-ын тухай хуулийн дагуу тооцоолол хийхэд судалгаанд оролцогчдын 98%-д 10 хувийн, 0.8%-д 15 хувийн, 1%-д 20 хувийн татвар ногдохоор байна.

График 7. Орлогод ногдох татварын бодит хэмжээ



Судалгаанд оролцогчдын 753 нь буюу 74% нь цалин, хөдөлмөрийн хөлсний орлогоос шууд суутгуулах хэлбэрээр ХХОАТ төлдөг гэж хариулсан хүмүүс хэдэн хувийн татвар төлдгөө мэддэг эсэхийг тодруулах зорилгоор “Та орлогоосоо хэдэн хувийн татвар төлдөг вэ?” гэсэн асуултад хариулсан дүнг татвар суутгаагүй нэг сарын цалингийн дүнд ногдох татварын дүнтэй харьцуулж харсан.

Үр дүнд нь цалин, хөдөлмөрийн хөлсний орлогоос шууд суутгуулах хэмжээгээр ХХОАТ төлдөг хүмүүсийн 67% буюу ойролцоогоор 10 хүн тутмын 7 нь төлж буй татварын хэмжээгээ мэддэг бол 33% буюу 10 хүн тутмын 3 нь мэдэхгүй (14% нь буруу, 19% нь хэлж мэдэхгүй) байна.

Хүснэгт 12. Цалин, хөдөлмөрийн хөлсний орлогоос ХХОАТ төлдөг хүмүүс төлж буй татварын хэмжээгээ мэддэг эсэх

	Та орлогоосоо хэдэн хувийн татвар төлдөг вэ?					
	1 хувь	**10 хувь**	**15 хувь**	**20 хувь**	**Хэлж мэдэхгүй байна**	**Нийт**
Зөв хариулсан	-	67%	-	-	-	**67%**
Буруу хариулсан	4%	0.3%	4%	7%	19%	**33%**
Нийт	**4%**	**67%**	**4%**	**7%**	**19%**	**100%**


ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨР БА ИРГЭНИЙ ТАТВАРЫН ХАРИЛЦАН ТОХИРОЛЦОО

Нийгмийн гэрээний онол бол төр, иргэдийн хоорондын харилцааг “иргэд төрд эрхээ зарж, эсвэл эрх болон үүргээ хуваалцаж, түүний төлөө төрөөс хамгаалалт, нийтийн үйлчилгээ авах” гэж тайлбарлах суурь философийн зарчим. Иргэд татвар төлөх нь төртэй байгуулсан гэрээний нэг хэсэг гэж үздэг (Bennett, 2017).

Судалгаанд оролцогчдын 68% буюу ойролцоогоор 10 хүн тутмын 7 нь татварын орлогоор төрийн үйлчилгээ санхүүжих ёстой гэдгийг дэмжиж байгаа нь төр–иргэний хоорондын нийгмийн гэрээг хүлээн зөвшөөрч байгааг харуулж байна. Харин 18% нь эргэлзээтэй, 14% нь дэмжихгүй гэж үзэж байна.

График 8. Таны төлсөн татвар төрийн үйлчилгээг (эрүүл мэнд, боловсрол, цагдаа шүүх, зам харилцаа, халамж гэх мэт) санхүүжүүлэхэд зарцуулагдаж байгааг та дэмжих үү?

Дундаж: 3.8



Тайлбар: *Огт дэмжихгүй бол 1, мэдээж дэмжих бол 5, 1-ээс 5 оноогоор үнэлсэн.*

Фокус бүлгийн ярилцлагад оролцогчдын дийлэнх нь татвар төрийн үйлчилгээг санхүүжүүлэхэд зарцуулагдаж буйг дэмжсэн ч халамжийг зорилтот бүлэгт хүргэх, төсвийн үрэлгэн байдлыг багасгах зэргээр төрийн хариуцлага, ил тод байдал нэмэгдэх хэрэгтэй гэсэн болзмол шаардлага тавьж байна. Харин цөөн хүн төрийн үйлчилгээний чанар, төсвийн буруу зарцуулалт, халамжийн хавтгайрсан бодлого зэргийг дурдаж, татвар иргэдэд дарамт болдог гэдэг агуулгаар дэмжихгүй гэж байр сууриа илэрхийлсэн. Тодруулбал,

Татвар төрийн үйлчилгээг (эрүүл мэнд, боловсрол, цагдаа шүүх, зам харилцаа, халамж гэх мэт) санхүүжүүлэхэд зарцуулагдаж байгааг дэмжинэ гэж хариулахдаа,

- Төрийн үйлчилгээ татвараар санхүүжих ёстой: төрийн үйлчилгээ (эрүүл мэнд, боловсрол, зам, аюулгүй байдал, халамж, хүүхэд хамгаалал) татваргүйгээр оршин тогтнох боломжгүй, хүн бүрд үр шимээ өгдөг үйлчилгээ тул татвараас санхүүжихээс өөр аргагүй.
- Нийгмийн эмзэг бүлгийг хамгаалах: Халамжийг бүхэлд нь биш, зөвхөн шаардлагатай зорилтот бүлэгт (хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, амьжиргааны доод түвшний өрх, эрүүл мэндийн шалтгаанаар хөдөлмөр эрхлэх боломжгүй хүн) өгөх нь зөв.

Татвар төрийн үйлчилгээг (эрүүл мэнд, боловсрол, цагдаа шүүх, зам харилцаа, халамж гэх мэт) санхүүжүүлэхэд зарцуулагдаж байгааг дэмжихгүй гэж хариулахдаа,


- Халамжийн бодлого хавтгайрсан: Халамж хавтгайрснаас иргэд ажил хийх сонирхолгүй болдог, жинхэнэ хэрэгтэй хүмүүстээ хүрдэггүй, улсын төсөвт хэт дарамт учруулдаг.

- Төсвийн үр ашиггүй зарцуулалт: төсвийн мөнгийг тансаг хурал, томилолтын зардал, ашиггүй төсөл, тендерт зарцуулахын зэрэгцээ эрх мэдэл бүхий албан тушаалтнууд хувьдаа завших, авлига хээл хахуульд зарцуулагддаг.
- Татварын дарамт өндөр: Хувираа бизнес эрхлэгчид голдуу татвар өндөр байдгаас орлого нь багасдаг, татвар болон үйлчилгээний чанар уялддаггүй.
- Төрийн үйлчилгээний чанар муу: Эмнэлэг, сургуулийн хүртээмж муу, чанар сул, замын нөхцөл муу, халамж зорилтот бүлэгтээ хүрдэггүй, эдгээр үйлчилгээг авахын тулд авлига өгөх асуудал гардаг зэргийг онцолж, өндөр татвар төлсөн ч үр дүн мэдрэгддэггүй гэж шүүмжилсэн.

Судалгаанд оролцогчдын 57% буюу ойролцоогоор 10 хүн тутмын 6 нь төр ба татварын харилцан хамаарал оршин тогтнохын үндэс гэж үзэж, нийгмийн гэрээг хүлээн зөвшөөрч байгаа боловч нийт иргэдийн 43% буюу ойролцоогоор 10 хүн тутмын 4 нь төр ба татварын харилцан хамааралд итгэл сул эсвэл үгүйсгэсэн байр суурьтай байна.

График 9. "Төр оршихуй дор татвар буй. Татвар буй дор төр оршмуй" гэдэг үгтэй Та санал нийлэх үү?

Дундаж: 3.5




Тайлбар: *Огт санал нийлэхгүй бол 1, мэдээж санал нийлэх бол 5, 1-ээс 5 оноогоор үнэлсэн.*

Төр ба татварын харилцан хамаарлын талаарх байр суурь судалгаанд оролцогчдын хүн ам зүйн үзүүлэлтийн хувьд ялгаа байгаа эсэхийг тодруулахад насны бүлэг, боловсрол, орлогын хувьд ($p<0.05$) ялгаатай үр дүн гарсан.

Төр ба татварын харилцан хамаарал оршин тогтнохын үндэс гэж үзэж, нийгмийн гэрээг хүлээн зөвшөөрөх байдал судалгаанд оролцогчдын нас, боловсрол, орлогын түвшин нэмэгдэхтэй зэрэгцэн нэмэгдэж байгаа бол нас, боловсрол, орлогын түвшин буурахтай зэрэгцэн хүлээн зөвшөөрөх байдал багассан зүй тогтолтой байна.

Тодруулбал, төр ба татварын харилцан хамаарал оршин тогтнохын үндэс гэж үзэж, нийгмийн гэрээг хүлээн зөвшөөрч байгаа хүмүүсийн дийлэнх нь 50-аас дээш настай, дээд/бакалавраас дээш боловсролтой, 2,300,000-аас дээш боловсролтой байгаа бол 18-24 настай, бүрэн бус дундаас тусгай дунд боловсролтой, 2,300,000 хүртэлх орлоготой хүмүүс төр ба татварын харилцан хамааралд итгэх итгэл сул байна.

График 10. “Төр оршихуй дор татвар буй. Татвар буй дор төр оршмуй” гэдэг үгтэй Та санал нийлэх үү? (Насны бүлэг, боловсрол, орлого)



Тайлбар: *Огт санал нийлэхгүй бол 1, мэдээж санал нийлэх бол 5, 1-ээс 5 оноогоор үнэлсэн.*

“Төр оршихуй дор татвар буй. Татвар буй дор төр оршмуй” гэдэг үгтэй санал нийлж байгаа эсэх шалтгааныг фокус бүлгийн ярилцлагын хүрээнд тодруулахад, дийлэнх нь төр ба татвар салшгүй холбоотой бөгөөд татвар бол төр оршин тогтнох үндэс, улсын төсөв татвараас бүрддэг тул төрийн үйлчилгээг (боловсрол, эрүүл мэнд, зам, дэд бүтэц, нийгмийн хамгаалал) татвараар бүрдүүлсэн төсөвгүйгээр хэрэгжүүлэх боломжгүй, улс орны хөгжил татвараас шууд хамааралтай гэж тайлбарлаж, санал нийлж буйгаа илэрхийлсэн.

Харин тус үгтэй санал нийлэхгүй байгаа нь татвар өндөр байгаа нь иргэдэд дарамт учруулдаг, татварын зарцуулалт хангалтгүй, үр ашиггүй зүйлд зарцуулдаг гэж харж буйгаар тайлбарлагдаж байна.

Өөрөөр хэлбэл, татварын зарцуулалт үр дүнтэй, ил тод мэдээллээр иргэдийг хангах тохиолдолд төр ба татварын харилцан хамаарлыг хүлээн зөвшөөрөх боломжтой гэж судалгаанд оролцогчид үзэж байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ТАТВАР БА ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЛИЛЦОО

Төр-татвар-үйлчилгээний солилцооны онол. Төсвийн солилцоо гэдэг нь хүмүүс татвар төлж буй орлого, хүлээн авч буй нийтийн бараа, үйлчилгээний хооронд шударга солилцоо явагддаг бол татварын хууль тогтоомжийг дагаж мөрдөх магадлал өндөр байдаг гэж үздэг. Энэхүү үзэл баримтлал нь татварыг дагаж мөрдөх нь зөвхөн хууль ёсны үүрэг төдийгүй "сэтгэл зүйн татварын гэрээ" буюу нийгмийн гэрээний нэг хэсэг бөгөөд иргэд татвар төлж буй төрийн үйл ажиллагааг хариуцдаг. Засгийн газрын ил тод байдал, хариуцлага, төсвийн зарцуулалтын шударга байдал, институтийн хууль ёсны байдал зэрэг хүчин зүйлүүд бүгд төсвийн харилцан солилцооны талаарх энэхүү ойлголтод нөлөөлдөг (Adams, 1965).

Иргэд “татвар төлснөөр чанартай үйлчилгээ авна” гэсэн хүлээлттэй байдаг. Судалгаанд оролцогчдоос энэхүү хүлээлтийг үнэлүүлэхэд дундаж үнэлгээ 1.7 буюу төр иргэдийн төлсөн татварыг шударгаар, иргэдэд хэрэгтэй, зөв зүйлд зарцуулж чадахгүй байна гэж харж байна.

Тодруулбал, судалгаанд оролцогчдын 78% буюу 10 хүн тутмын 8 нь төр иргэдийн төлсөн татварыг шударгаар, иргэдэд хэрэгтэй, зөв зүйлд зарцуулж чаддаггүй гэж үзжээ.

График 11. Төр иргэдийн төлсөн татварыг шударгаар, иргэдэд хэрэгтэй, зөв зүйлд зарцуулж чадаж байгаа эсэхийг Та хэрхэн үнэлэх вэ?

Дундаж: 1.7



Тайлбар: *Маш муу бол 1, маш сайн бол 5, 1-ээс 5 оноогоор үнэлсэн.*


“Татвар төлснөөр чанартай үйлчилгээ авна” гэсэн хүлээлтийн үнэлгээ судалгаанд оролцогчдын хүн ам зүйн үзүүлэлтийн хувьд ялгаа байгаа эсэхийг тодруулахад боловсрол, ажилладаг салбар, орлогын хувьд ($p<0.05$) ялгаатай үр дүн гарсан.

Төр иргэдийн төлсөн татварыг шударгаар, иргэдэд хэрэгтэй, зөв зүйлд зарцуулж чаддаггүй гэх хандлага боловсрол, орлогын түвшин нэмэгдэхтэй зэрэгцэн нэмэгдэж, төрийн байгууллагаас бусад салбарт ажиллагсдын дунд мөн сэтгэл хангалуун бус байдал өндөр байна.

Тодруулбал, бага зэргийн ялгаа буюу дундаж үнэлгээ 1.7-оос дээш үнэлгээ өгсөн нь бүрэн дунд хүртэлх боловсролтой, төрийн албанд ажилладаг, 1,300,000 хүртэлх орлоготой хүмүүс байна.

Харин дунджаас доош үнэлгээг тусгай дундаас дээш боловсролтой, 1,300,000-аас дээш сарын орлоготой, төрийн албанд ажилладаг хүмүүс өгчээ.

График 12. Төр иргэдийн төлсөн татварыг шударгаар, иргэдэд хэрэгтэй, зөв зүйлд зарцуулж чадаж байгаа эсэхийг Та хэрхэн үнэлэх вэ? (Боловсрол, ажилладаг салбар, орлогоор)



Тайлбар: *Маш муу бол 1, маш сайн бол 5, 1-ээс 5 оноогоор үнэлсэн.*

ХХОАТ-ын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу График 13-т заасан дүнгээр татвар төлөхөөр хуульчилсныг хэрхэн үнэлж буйг тодруулахад дундаж үнэлгээ 1.8 буюу татварын хувийг нэлээн өндөр гэж үзэж байна.

Тодруулбал, судалгаанд оролцогчдын 81% буюу 10 хүн тутмын 8 нь Хувь хүний сарын орлого 10 сая хүртэлх бол 10%, 10-15 сая бол 15%, 15 саяас дээш бол 20%-ийн татвар төлөхөөр хуульчилсан байгааг өндөр гэж үнэлж байна.

График 13. Хувь хүний сарын орлого 10 сая хүртэлх бол 10%, 10-15 сая бол 15%, 15 саяас дээш бол 20%-ийн татвар төлөхөөр хуульчилсан байдаг. Та тус татварын хувь хэмжээг хэрхэн үнэлэх вэ?

Дундаж: 1.8




Тайлбар: *Маш өндөр бол 1, маш бага бол 5, 1-ээс 5 оноогоор үнэлсэн.*

Татварын хувь хэмжээг үнэлэх байдал судалгаанд оролцогчдын хүн ам зүйн үзүүлэлтийн хувьд ялгаа байгаа эсэхийг тодруулахад насны бүлэг, орлогын хувьд ($p<0.05$) ялгаатай үр дүн гарсан.

Насны бүлгээр харвал, 25-49 насны хүмүүс дунд татвар өндөр гэж үзэх хандлага хамгийн өндөр байгаа бол 18-24 нас, 50-аас дээш насныхан татвар өндөр гэж үзэх хандлага буурсан.

Харин орлогоор харьцуулж харвал, 3,800,000 төгрөгөөс дээш сарын орлоготой хүмүүс татварын хувь хэмжээг өндөр гэж үзэж байгаа нь хамгийн их байгаа бол 800,000 хүртэлх орлоготой хүмүүсийн хувьд өндөр гэж үзэх байдал буурсан дүнтэй байна.

График 14. Хувь хүний сарын орлого 10 сая хүртэлх бол 10%, 10-15 сая бол 15%, 15 саяас дээш бол 20%-ийн татвар төлөхөөр хуульчилсан байдаг. Та тус татварын хувь хэмжээг хэрхэн үнэлэх вэ? (Насны бүлэг, орлогоор)



Тайлбар: *Маш өндөр бол 1, маш бага бол 5, 1-ээс 5 оноогоор үнэлсэн.*

График 13-т харуулсанчлан судалгаанд оролцогч 10 хүн тутмын 8 нь одоогийн ХХОАТ-ын хувь хэмжээг өндөр гэж үзсэн.

Тэгвэл татвар бууруулах ёстой эсэх талаарх байр суурь, шалтгааныг фокус бүлгийн ярилцлагаар тодруулахад, оролцогчдын 67% буюу ойролцоогоор 10 хүн тутмын 7 нь бууруулах ёстой гэж үзсэн. Шалтгаан нь татварын хувь хэмжээ өндөр байснаар татвар төлөгчдийн тоо буурах, орлогоо нуун дарагдуулах эрсдэл үүсэж, эдийн засагт төдийлөн тэлэлт авчрахгүй байгаа. Татварын хувь хэмжээг бууруулснаар хувиараа бизнес эрхлэгчид болон татвар төлөгчдийн тоо нэмэгдэж, эдийн засаг тэлэх боломж бүрдэнэ гэж судалгаанд оролцогчид үзэж байна.

Ярилцлагад оролцогчдын 19% буюу ойролцоогоор 10 тутмын 2 нь татвар бууруулах хэрэгтэй талаар сайн хэлж мэдэхгүй, нөхцөлт байдлаар бууруулж болох юм гэж хариулсан. Тухайлбал, татвар бууруулах бол орлогын түвшнийг шаталж, татварын хэлбэрээс шалтгаалж

өөр өөр хувь хэмжээгээр тогтоох, гэхдээ төрийн үйлчилгээний хүртээмж, чанарыг алдагдуулахгүй байхад анхаарах хэрэгтэй гэсэн.


Харин 12% буюу ойролцоогоор 10 хүн тутмын нэг нь татварын хувь хэмжээг бууруулах хэрэггүй гэж хариулсан. Тодруулбал, одоогийн татварын хэмжээ боломжийн, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлаа харахад ч татвар бууруулах нөхцөл үүсээгүй, харин бүх хүн татвараа төлдөг байхад анхаарч ажиллах хэрэгтэй гэж үзэж байна.

Татварын хувь хэмжээг өндөр гэж үнэлэх хандлага орлогын түвшнээс бага зэрэг хамааралтай боловч энэхүү хамаарал статистикийн хувьд сул (R^2=0.007). Өндөр орлоготой хүмүүс татварыг харьцангуй өндөр гэж үнэлэх хандлагатай байна.

Тодруулбал, татварын хэмжээг өндөр гэж үзэх байдал буурах тусам судалгаанд оролцогчдын сарын орлогын хэмжээ буурч байна. Өөрөөр хэлбэл, татварыг “бага байна” гэж үздэг хүмүүсийн орлого дунджаас бага, харин “татвар өндөр байна” гэж үздэг хүмүүсийн орлого дунджаас илүү өндөр байна.

R^2 = 0.007 буюу 0.7% гэдэг нь орлогын хэлбэлзлийн ердөө 0.7%-ийг татварын талаарх үнэлгээгээр тайлбарлаж байна. Энэ нь статистикийн хувьд утга багатай, өөрөөр хэлбэл орлого татварын талаарх хандлагад бараг нөлөөлдөггүй аж.

График 15. Нэг сарын орлого болон татварын хувь хэмжээний үнэлгээний регрессийн шинжилгээ




Хувь хүний сарын орлого 10 сая хүртэлх бол 10%, 10-15 сая бол 15%, 15 саяас дээш бол 20%-ийн татвар төлөхөөр хуульчилсан байдаг. Та тус татварын хувь хэмжээг хэрхэн үнэлэх вэ?

Судалгаанд оролцогчдын 98% нь татвар бууруулахыг дэмждэг бол 2% нь дэмждэггүй.

Тэгвэл татвар бууруулах бодлогыг дэмждэг бол үүний үр дүнд төрийн үйлчилгээг хумьж, хязгаарлахыг зөвшөөрөх эсэхийг тодруулахад 50% нь буюу 2 хүн тутмын нэг нь зөвшөөрөхгүй гэж хариулсан бол 29% нь зөвшөөрнө, 19% нь эргэлзэж буйгаа илэрхийлсэн байна.

График 16. Та татвар бууруулах бодлогыг дэмждэг бол үгний үр дүнд төрийн үйлчилгээг (цагдаа, боловсрол, эрүүл мэнд, дэд бүтэц гэх мэт) хумьж, хязгаарлахыг зөвшөөрөх үү?)

Дундаж: 2.6




Тайлбар: *Огт зөвшөөрөхгүй бол 1, мэдээж зөвшөөрөх бол 5, 1-ээс 5 оноогоор үнэлсэн.*

Татвар бууруулсны үр дүнд төрийн үйлчилгээг хумьж, хязгаарлахыг зөвшөөрөх эсэхийг судалгаанд оролцогчдын хүн ам зүйн үзүүлэлтээр ялгаа байгаа эсэхийг тодруулахад насны бүлэг, хүйсийн хувьд ($p<0.05$) ялгаатай үр дүн гарсан.

Татвар бууруулсны үр дүнд төрийн үйлчилгээг хумьж, хязгаарлахыг дэмжих байдал 50-аас дээш насныхан болон эмэгтэйчүүдийн дунд бусадтай харьцуулахад өндөр байна.

График 17. Та татвар бууруулах бодлогыг дэмждэг бол үгний үр дүнд төрийн үйлчилгээг (цагдаа, боловсрол, эрүүл мэнд, дэд бүтэц гэх мэт) хумьж, хязгаарлахыг зөвшөөрөх үү? (Насны бүлэг, хүйсээр)



Тайлбар: *Огт зөвшөөрөхгүй бол 1, мэдээж зөвшөөрөх бол 5, 1-ээс 5 оноогоор үнэлсэн.*

Татварын хэмжээг үнэлж буй байдал болон татвар бууруулж төрийн үйлчилгээг хумьж, хязгаарлах талаарх үнэлгээ хооронд хамаарал байгаа эсэхийг шалгахад p=0.004 буюу статистикийн хувьд ач холбогдолтой хамаарал байсан.

ХХОАТ-ын хэмжээг өндөр гэж үзэж байгаа ч татвар бууруулж төрийн үйлчилгээг хумьж хязгаарлахыг зөвшөөрөхгүй гэх хандлага өндөр байна. Өөрөөр хэлбэл, татварын хувь хэмжээг өндөр гэж үзэж байгаа ч одоогийн төрөөс үзүүлж буй цагдаа, боловсрол, дэд бүтэц гэх мэт нийгмийн үйлчилгээг хадгалах эрмэлзэл өндөр байна.

Хүснэгт 13. Татварын хэмжээг үнэлж буй байдал болон татвар бууруулж төрийн үйлчилгээг хумьж, хязгаарлах талаар хамаарал


		Хувь хүний сарын орлого 10 сая хүртэлх бол 10%, 10-15 сая бол 15%, 15 саяас дээш бол 20%-ийн татвар төлөхөөр хуульчилсан байдаг. Та тус татварын хувь хэмжээг хэрхэн үнэлэх вэ?			
		Өндөр	**Боломжийн**	**Бага**	**Нийт**
Та татвар бууруулах бодлогыг дэмждэг бол үүний үр дүнд төрийн үйлчилгээг (цагдаа, боловсрол, эрүүл мэнд, дэд бүтэц гэх мэт) хумьж, хязгаарлахыг зөвшөөрөх үү?	**Зөвшөөрнө**	23%	5%	1%	**29%**
	Магадгүй	15%	4%	1%	**19%**
	Зөвшөөрөхгүй	**42%**	7%	1%	**50%**
	Татвар бууруулах бодлогыг дэмждэггүй	1%	1%	-	**2%**
	Нийт	**81%**	**16%**	**3%**	**100%**

Татвар төлөхгүйгээр төрийн үйлчилгээг өөрийн мөнгөөр авахад бэлэн эсэхийг тодруулахад дундаж үнэлгээ 2.5 буюу бэлэн биш гэсэн хандлагатай байна.

Тодруулбал, судалгаанд оролцогчдын 54% буюу ойролцоогоор 2 хүн тутмын нэг нь татвар төлөхгүйгээр төрийн үйлчилгээг өөрийн мөнгөөр авахад бэлэн биш гэж хариулсан бол 26% буюу 4 хүн тутмын нэг нь бэлэн гэж хариулж, 20% буюу 5 хүн тутмын нэг нь магадгүй буюу эргэлзсэн хариултыг өгсөн.

График 18. Та татвар төлөхгүйгээр төрийн үйлчилгээг (цагдаа, боловсрол, эрүүл мэнд, дэд бүтэц гэх мэт) өөрийн мөнгөөр авахад бэлэн үү?

Дундаж: 2.5



Тайлбар: *Огт бэлэн биш бол 1, мэдээж бэлэн бол 5, 1-ээс 5 оноогоор үнэлсэн.*

Татвар төлөхгүйгээр төрийн үйлчилгээг өөрийн мөнгөөр авахад бэлэн эсэх болон судалгаанд оролцогчдын хүн ам зүйн үзүүлэлт хооронд хамаарал байгаа эсэхээс шалтгаалан насны бүлэг, хүйс, боловсрол, орлогын хувьд ($p<0.05$) ялгаатай үр дүн гарсан.


Нас, боловсролын түвшин болон орлого өндөр байх тусам татвар төлөхгүйгээр төрийн үйлчилгээг өөрийн мөнгөөр авахад бэлэн гэж үзэх хандлагатай байна.

Тодруулбал, Татвар төлөхгүйгээр төрийн үйлчилгээг өөрийн мөнгөөр авахад бэлэн биш гэж 50-аас дээш настай, бүрэн дунд болон түүнээс доош боловсролтой, 2,300,000 хүртэлх орлоготой хүмүүсийн дунд жин дарж байгаа бол бэлэн гэж хариулсан дүн 18-39 настай, тусгай дундаас дээш боловсролтой, сарын 2,300,000-аас дээш орлоготой хүмүүс байна.

Харин хүйсийн хувьд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдтэй харьцуулахад татвар төлөхгүйгээр төрийн үйлчилгээг өөрийн мөнгөөр авахад бэлэн гэж хариулсан нь өндөр байна.

График 19. Та татвар төлөхгүйгээр төрийн үйлчилгээг (цагдаа, боловсрол, эрүүл мэнд, дэд бүтэц гэх мэт) өөрийн мөнгөөр авахад бэлэн үү? (Насны бүлэг, хүйс, боловсрол, орлогоор)

Дундаж:




Тайлбар: *Огт бэлэн биш бол 1, мэдээж бэлэн бол 5, 1-ээс 5 оноогоор үнэлсэн.*

“Монгол Улсынхаа хөгжлийг дэлхийн жишигт хүргэхийн тулд татвараа нэмэгдүүлэхийг зөвшөөрөх үү?” гэж судалгаанд оролцогчдоос асуухад дундаж үнэлгээ 1.8 буюу зөвшөөрөхгүй гэсэн байр суурь давамгайлж байна.

Тодруулбал, судалгаанд оролцогчдын 79% буюу ойролцоогоор 10 хүн тутмын 8 нь тус асуултад зөвшөөрөхгүй гэж хариулсан бол 9% буюу ойролцоогоор 10 хүн тутмын нэг нь зөвшөөрнө гэж хариулсан.

График 20. Та Монгол Улсынхаа хөгжлийг дэлхийн жишигт нийцүүлэхийн тулд татвараа нэмэгдүүлэхийг зөвшөөрөх үү?

Дундаж: 1.8




***Тайлбар:** Огт зөвшөөрөхгүй бол 1, мэдээж зөвшөөрөх бол 5, 1-ээс 5 оноогоор үнэлсэн.*

“Монгол Улсынхаа хөгжлийг дэлхийн жишигт хүргэхийн тулд татвараа нэмэгдүүлэхийг зөвшөөрөх үү?” гэсэн асуултад хариулсан байдлыг судалгаанд оролцогчдын хүн ам зүйн үзүүлэлтээр харахад оршин суугаа газар, насны бүлэг, орлогын хувьд ($p<0.05$) ялгаатай үр дүн гарсан.

Монгол Улсынхаа хөгжлийг дэлхийн жишигт хүргэхийн тулд татвараа нэмэгдүүлэхийг зөвшөөрөхгүй гэх байр суурь Улаанбаатар хотод оршин суудаг, 25-49 настай, 2,300,000-аас дээш орлоготой хүмүүсийн дунд илүү байна. Харин зөвшөөрнө гэх нааштай хандлага аймаг, орон нутагт амьдардаг, 18-24 нас, 50-аас дээш насны, 800,000 хүртэлх сарын орлоготой хүмүүсийн дунд бусадтай харьцуулахад өндөр байна.

График 21. Та Монгол Улсынхаа хөгжлийг дэлхийн жишигт нийцүүлэхийн тулд татвараа нэмэгдүүлэхийг зөвшөөрөх үү? (Оршин суугаа газар, насны бүлэг, орлогоор)



***Тайлбар:** Огт зөвшөөрөхгүй бол 1, мэдээж зөвшөөрөх бол 5, 1-ээс 5 оноогоор үнэлсэн.*

Фокус бүлгийн ярилцлагад оролцогчдоос “Та Монгол Улсынхаа хөгжлийг дэлхийн жишигт нийцүүлэхийн тулд татвараа нэмэгдүүлэхийг зөвшөөрөх үү?” гэж асуухад Монгол Улсын хөгжлийг дэмждэг ч татварын өсөлтөөр бус, төрийн үр ашигтай засаглалд тулгуурлан дэлхийн жишигт хүрэх ёстой. Татвар нэмэхийг эсэргүүцэж буй үндсэн шалтгаан нь төрд итгэх итгэлийн хомсдол, амьжиргааны түвшин, авлигын асуудал, нөөцөө зөв ашиглаагүй байдал гэж хариулсан. Тодруулбал,

Зөвшөөрөхгүй байгаа гол шалтгаан нь татвар нэмсэн ч Монгол Улсын хөгжилд зарцуулагдахгүй гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, өнөөдрийн байдлаар татварын мөнгөөр бүрдсэн улсын төсвийн зарцуулалт үр ашиггүй, үрэлгэн, хариуцлагагүй, ил тод биш, дээр нь авлига хээл хахуулийн асуудал шийдэгдээгүй байхад татвар нэмж Монгол Улсыг хөгжүүлнэ гэвэл шударга биш гэж судалгаанд оролцогчид үзэж байна.

Мөн иргэдийн орлого бага, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ өндөр, цалин нь амьдралд нь хүрэлцэхгүй энэ үед татвар нэмчихвэл ард түмний амьдралд шууд сөрөг нөлөө үзүүлнэ.

Харин Монгол Улсаа дэлхийн жишигт хүргэхийг хүсэж байгаа бол татвар нэмэх бус байгалийн баялгаа шударга хуваарилж, төр нь ил тод, хариуцлагатай, сайн засаглалтай байхад анхаарах нь зүйтэй гэж хариулсан.

Цөөн хүн бодитоор боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, дэд бүтэц зэрэг төрөөс үзүүлж буй үйлчилгээний чанар сайжирч, төсөв ил тод, хяналттай, хариуцлагатай болж чадвал татвараа нэмэгдүүлэхийг зөвшөөрнө гэжээ.

ТАВДУГААР БҮЛЭГ. БУСДЫН ХАНДЛАГА ТАТВАР ТӨЛӨХ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ НЬ

Нийгмийн хүлээлтийн онолын дагуу хүмүүсийн зан үйл нь тухайн нөхцөл байдалд ямар зан авир зөв гэж үзэгдэж буй хүлээлт болон бусдын үнэлэмж, байр сууринд тулгуурлан бүрэлддэг (Fishbein, 2010). Хүмүүс нийгмийн орчиндоо бусдын зан үйлийг ажиглаж, олонхын үзэл бодол, заншлаас хазайхгүй байхыг эрмэлздэг бөгөөд энэ нь нийтийн зөвшөөрөгдсөн нормыг дагах зан үйл үүсгэдэг (Cialdini, 2004) Иймээс хэрэв нийт иргэдийн дийлэнх нь татвараа тогтмол төлдөг бол энэ нь “зөв зан үйл” гэсэн нийгмийн хүлээлтийг бий болгож, хувь хүмүүс татвараа төлөх хандлагыг нэмэгдүүлдэг (Wenzel, 2005).

Судалгаанд оролцогчид бусдын нөхцөл байдлыг дүгнэж, өөрийгөө адилтгадаг үйлдлийг нийгмийн орчны зан үйл юм. Тус байдал ХХОАТ-ын төлөлтийн асуудал дээр гардаг эсэхийг тодорхойлох зорилгоор “Зарим хүн татвар төлөхгүй байгаа тул би татвар төлөхгүй байсан нь дээр” гэдэг үгтэй Та санал нийлэх үү? гэж асуусан.


Үр дүнг харвал, дундаж үзүүлэлт 1.8 буюу “Зарим хүн татвар төлөхгүй байгаа тул би татвар төлөхгүй байсан нь дээр” гэдэг үгтэй санал нийлэхгүй талд буюу татвар төлөх нь зүйтэй гэх хандлагатай байна.

Тодруулбал, судалгаанд оролцогчдын 55% буюу ойролцоогоор 2 хүн тутмын нэг нь тус бодомжтой санал нийлэхгүй байгаа нь татвар төлөх эсэх шийдвэрийг бусдын зан үйлд бус, өөрийн хариуцлагад тулгуурлуулдаг болохыг харуулсан.

Харин 5 хүн тутмын нэг нь тус бодомжтой санал нийлж, 5 хүн тутмын нэг нь магадлалтай гэж хариулсан нь бусдын зан үйлийг дагаж татвар төлөхгүй байх эрсдэлтэй болохыг харуулж байна.

График 22. “Зарим хүн татвар төлөхгүй байгаа тул би татвар төлөхгүй байсан нь дээр” гэдэг үгтэй Та санал нийлэх үү?

Дундаж: 1.8



Тайлбар: *Огт санал нийлэхгүй бол 1, мэдээж санал нийлэх бол 5, 1-ээс 5 оноогоор үнэлсэн.*

“Зарим хүн татвар төлөхгүй байгаа тул би татвар төлөхгүй байсан нь дээр” гэдэг үгтэй санал нэгдэх эсэх хариултын шалтгааныг фокус бүлгийн ярилцлагаар тодруулсан.

Тус бодомжтой санал нийлж буй шалтгаан нь татвар төлөлтийн тэгш бус болон шударга бус байдал, татварын мөнгөний зарцуулалтад итгэл алдарсан, татвар төлөлтийн хяналт сул байдал байна. Тодруулбал,

Татвар төлөлт тэгш бус: Монгол Улсад ажиллаж, амьдарч байгаа бүх хүн тодорхой хэмжээнд орлого олж байгаа хэр нь зарим хүн татвар төлөхөөс зайлсхийж буйгаас татвар төлж байгаа иргэд хохирдог нь татварын тогтолцоо шударга бус байгааг илэрхийлж байна.

Татварын мөнгөний зарцуулалт: Татвараас бүрдсэн төсөв зөв зарцуулагддаггүй, татварын мөнгийг эрх мэдэл бүхий албан тушаалтан хувьдаа завшдаг, хүнд суртал, авлигын мөртэй байхад татвар төлөх хүсэл буурч байгаа.

Татвараа төлдөг хүмүүст дарамт их ирдэг: Улсын төсвийг цөөн татвар төлөгч нар бүрдүүлж байгаа нь татварын ачаалал жигд бус буюу шударга бус байгаагийн илрэл. Татвар төлдөг цөөн хүмүүст татварын дарамт, шахалт илүү мэдрэгддэг.

Татвар төлөлтийн хяналт сул: Татвар төлөлтийн хяналт сул байдгаас бусад хүн татвар төлөхгүй байхад би татвар бүрэн төлөх албагүй, энэ нь тэнэг хүний үйлдэл гэх хандлагатай байдаг гэжээ.

Тус бодомжтой санал нийлэхгүй байгаа нь ямар шалтгаантай болохыг тодруулахад, татвар төлөх нь ёс суртахуунтай, хариуцлагатай, татварын мөнгийг иргэдийн хэрэгцээ шаардлагатай зүйлд зарцуулдаг тухай мэддэг хүмүүсийн үйлдэл тул “зарим хүн татвар төлөхгүй байхад би татвар төлөхгүй байж болно” гэсэн бодомжтой санал нийлэхгүй гэж тайлбарласан. Тодруулбал,

Татвар төлөх нь иргэний үүрэг: Монгол Улсын иргэн учраас үүргээ биелүүлж, татвар төлж өөрөөс шалтгаалах зүйлээ хийж байж улс орон тогтвортой байх үндэс болно.

Бусад нь татвараа төлөхгүй байгаа нь миний шийдвэрийг тодорхойлохгүй: Зарим хүн татвараа төлөхгүй байлаа би татвар төлөхгүй гэж байгаа нь ёс суртахууны хувьд зарчимгүй үйлдэл.

Улсын хөгжил татвараас шууд хамаардаг: Татвараас бүрдсэн төсвөөр төрийн үйлчилгээг (эмнэлэг, сургууль, дэд бүтэц гэх мэт) иргэд авдаг тул иргэн бүр татвар төлөх ёстой.

“Зарим хүн татвар төлөхгүй байгаа тул би татвар төлөхгүй байсан нь дээр” гэдэг бодомжтой зарим талаар санал нийлнэ гэсэн хариулт өгсөн хүмүүс татварын мөнгөний зарцуулалтын ил тод байдал, хяналт, орлогын хүрэлцээгүй байдалтай холбож шалтгаанаа тайлбарласан. Тодруулбал:

Татвар төлөлт, зарцуулалтын хяналт сул: Татварын мөнгө ямар зүйлд зарцуулагддаг талаарх мэдээлэл ил тод биш байдаг тул би татвар төлөхгүй байснаараа буруу зүйл хийж байна гэсэн сэтгэгдэл төрдөггүй.


Орлогын хүрэлцээгүй байдал: Орлого багатай, орлого нь амьжиргаагаа залгуулахад хүрэлцдэггүй тул татвар төлөх хүсэлтэй байсан ч чадахгүйд хүрдэг.

Судалгаанд оролцогчдын эргэн тойронд ХХОАТ төлдөггүй хүн байдаг эсэхийг тодруулахад дундаж үнэлгээ 1.8 буюу татвар төлөлтийн шударга, тэгш байдал алдагдсаныг харуулж байна. Тодруулбал,

Иргэдийн 62% буюу ойролцоогоор 10 хүн тутмын 6-ийнх нь эргэн тойронд ямар нэг байдлаар ХХОАТ төлдөггүй хүн байдаг бол 10 хүн тутмын 4-ийнх нь эргэн тойронд тийм хүн байдаггүй гэж хариулсан.

График 23. Таны эргэн тойронд Хувь хүний орлогын албан татвар төлдөггүй хүн байдаг уу?

Дундаж: 1.8



Тайлбар: *Маш их бол 1, огт байдаггүй бол 5, 1-ээс 5 оноогоор үнэлсэн.*

Фокус бүлгийн ярилцлагын үеэр ХХОАТ төлдөггүй хүмүүс эргэн тойронд нь байдаг болохыг харсан хүмүүс байгаа нь “Монгол Улсад татвар төлж ч болдог, төлөхгүй ч байж болдог” гэсэн ойлголтыг нийгэмд бий болгож буй буруу жишиг гэж тайлбарласан.

Мөн Татварын ерөнхий газарт татвар төлөгчдийн мэдээлэл гүйцэд байдаггүй, бүх хүн татвар төлж байхад их хэмжээний малтай малчид, өндөр орлоготой хувиараа бизнес эрхлэгч нар, орлого багатай иргэд татвар төлдөггүй дүр зураг байдаг тухай дурдсан болно.

Судалгаанд оролцогчдын 1,018 нь “яагаад зарим хүн татвар төлдөггүй гэж бодож байна вэ” гэсэн асуултад давхардсан тоогоор 1,472 хариулт өгсөн.

Үр дүнгээс харвал, ажилгүйдэл, албан бус хөдөлмөр эрхлэлт, тогтмол бус орлого, орлогын хүрэлцээгүй байдал болон амьжиргааны түвшин доогуур зэрэг ажил эрхлэлт, эдийн засгийн хүчин зүйлээс шалтгаалж зарим хүн татвар төлдөггүй гэж үзэх байдал хамгийн түгээмэл байна.

Мөн татварын мөнгөний үр ашиггүй зарцуулалт, татварын бодлогын шударга бус, ил тод бус байдал, хяналт сул зэрэг татварын системийн асуудал болон иргэд татвар хэрхэн төлөх талаарх мэдээлэл, ойлголт дутмаг, хувь хүний хандлага, итгэл үнэмшил сул байдаг нь дараах шалтгаан болж байна.

График 24. Яагаад зарим хүн татвар төлдөггүй гэж бодож байна вэ?



“Зарим хүн татвар төлөхгүй байгаа тул би татвар төлөхгүй байсан нь дээр” гэдэг үгтэй Та санал нийлэх үү?” гэдэг асуултад ХХОАТ төлдөг эсэх нь хамааралтай эсэхэд корреляцийн хамаарал тооцож үзэхэд sig 0.000 буюу татвар төлдөг эсэх ба “татвар төлөх тухай үзэл бодол” хооронд хүчтэй корреляцийн хамаарал байгааг харуулж байна.

ХХОАТ төлдөг хүмүүс “Зарим Зарим хүн татвар төлөхгүй байгаа тул би татвар төлөхгүй байсан нь дээр” гэдэг үгтэй санал нийлэхгүй гэж үзэх байдал 45% (ХХОАТ төлдөг хүмүүсийг 100% гэж тооцвол 59% нь) байгаа нь татвар төлдөг хүмүүс хүн бүр татвар төлөх нь шударга гэж үзэх байдлыг илүү дэмжиж буйг харуулж байна. Харин ХХОАТ төлдөггүй хүмүүсийн талаас илүү нь татвар төлөхгүй байх нь зүйтэй гэх хандлагатай байна.

Мөн татвар төлдөг хүмүүсийн 32% (ХХОАТ төлдөг хүмүүсийг 100% гэж тооцвол 41% нь) нь зарим хүн татвар төлөхгүй байхад би татвар төлөхгүй байж болно гэх хандлагатай байгаа нь татварын шударга байдалд итгэл сул байгаагийн илрэл юм.

Хүснэгт 14. “Зарим хүн татвар төлөхгүй байгаа тул би татвар төлөхгүй байсан нь дээр” гэдэг үгтэй Та санал нийлэх үү? (Та Хувь хүний орлогын албан татвар төлдөг үү?)

		Та Хувь хүний орлогын албан татвар төлдөг үү?			
		Төлдөг	**Хааяа төлдөг**	**Төлдөггүй**	**Нийт**
“Зарим хүн татвар төлөхгүй байгаа тул би татвар төлөхгүй байсан нь дээр” гэдэг үгтэй Та санал нийлэх үү?	**Санал нийлнэ**	16%	2%	**4%**	22%
	Магадгүй	16%	2%	**4%**	23%
	Санал нийлэхгүй	**45%**	3%	7%	55%
	Нийт	**78%**	**7%**	**15%**	**100%**

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ПРОГРЕССИВ ТАТВАРЫГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ БАЙДАЛ

Прогрессив бүтэц нь өндөр орлогод өндөр татварын хувь ногдуулснаар дахин хуваарилалт хийж, нийгмийн халамж/шударга байдлыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хөдөлмөр-шийдвэрт үүсэх зохисгүй гажуудлыг аль болох бага байлгах тэнцвэрийн асуудал юм (Mirrlees, 1971). Засаг нь хувь хүний жинхэнэ бүтээмж/хичээл зүтгэлийг шууд ажиглаж чаддаггүй (асимметрик мэдээлэл). Тиймээс татварын шугаман бус (non-linear) хуваарийг сонгохдоо: (i) урамшууллын нийцэл (incentive compatibility), (ii) нөөцийн хязгаар, (iii) нийгмийн халамжийн жин зэргийг зэрэг хангах ёстой, ингэснээр прогрессив бүтэц хэдэн шаттай, ямар хувьтай байх нь илэрхийлэгддэг.

Прогрессив татварын онцлог нь бага орлоготой хүн өндөр орлоготой хүнтэй ижил хэмжээний татвар төлөх тохиолдолд ядуурлын хэмжээ нэмэгдэж, нийгэмд илүү ачаалал үүсэх эрсдэлийг бий болгодог явдал юм.


Монгол Улсын хувьд ч орлогын хэмжээнээс хамаарсан прогрессив татварын бодлого хэрэгждэг билээ.

Энэхүү татварын бодлогыг ойлгож, хүлээн зөвшөөрдөг эсэхийг тодруулах зорилгоор судалгаанд оролцогчдоос “Өндөр орлоготой хүмүүс илүү өндөр хувьтай татвар төлж, нийгмийн өмнө илүү хариуцлага үүрэх нь зүйтэй” гэдэг үгтэй Та санал нийлэх үү? гэж асууж дундаж үнэлгээ гаргахад 3.1 буюу прогрессив татварын бодлогыг дэмжих хандлагатай байна.

Тодруулбал, тус бодомжтой судалгаанд оролцогчдын 63% буюу ойролцоогоор 10 хүн тутмын 6 нь ямар нэг байдлаар санал нийлж байгаа бол 37% буюу ойролцоогоор 10 хүн тутмын 4 нь санал нийлэхгүй гэж хариулжээ.

График 25. “Өндөр орлоготой хүмүүс илүү өндөр хувьтай татвар төлж, нийгмийн өмнө илүү хариуцлага үүрэх нь зүйтэй” гэдэг үгтэй Та санал нийлэх үү?

Дундаж: 3.1



Тайлбар: *Огт санал нийлэхгүй бол 1, мэдээж санал нийлэх бол 5, 1-ээс 5 оноогоор үнэлсэн.*


Прогрессив татварын бодлогыг дэмжих эсэх байдлыг судалгаанд оролцогчдын хүн ам зүйн үзүүлэлтээр харьцуулахад насны бүлэг, хүйс, боловсрол, ажилладаг салбар, орлогын хувьд ($p<0.05$) ялгаатай үр дүн гарсан.

“Өндөр орлоготой хүмүүс илүү өндөр хувьтай татвар төлж, нийгмийн өмнө илүү хариуцлага үүрэх нь зүйтэй” гэдэг үгтэй санал нийлэх байдал 40-өөс дээш насны, эмэгтэй, боловсролгүй/бага сургуулийн болон тусгай дунд боловсролтой, төрийн албанд ажилладаг, 800,000-1,800,000, 3,800,001-4,300,000 төгрөгийн орлоготой хүмүүсийн дунд бусадтай харьцуулахад өндөр байна.

Харин тус үгтэй санал нийлэхгүй хүмүүс 18-39 настай, эрэгтэй, бүрэн дунд болон дээд/бакалаврын боловсролтой, хувийн байгууллага болон хувиараа бизнес эрхэлдэг, сарын 4,300,000 төгрөгөөс дээш орлоготой хүмүүсийн дунд жин дарж байна.

График 26. “Өндөр орлоготой хүмүүс илүү өндөр хувьтай татвар төлж, нийгмийн өмнө илүү хариуцлага үүрэх нь зүйтэй” гэдэг үгтэй Та санал нийлэх үү? (Насны бүлэг, хүйс, боловсрол, ажилладаг салбар, орлогоор)

Дундаж:



Тайлбар: *Огт санал нийлэхгүй бол 1, мэдээж санал нийлэх бол 5, 1-ээс 5 оноогоор үнэлсэн.*

“Өндөр орлоготой хүмүүс илүү өндөр хувьтай татвар төлж, нийгмийн өмнө илүү хариуцлага үүрэх нь зүйтэй” гэдэг үгтэй Та санал нийлэх үү? Гэсэн асуултад хэрхэн хариулсан шалтгааныг фокус бүлгийн ярилцлагын хүрээнд тодруулсан.

Тус бодомжтой санал нийлж буй шалтгааныг харвал, өндөр орлоготой хүмүүс нийгмийн баялгаас илүүг хүртдэг, нөгөөтэйгүүр өндөр орлоготой байх нь илүү боломж, нийгмийн

дэмжлэгийг авдаг тул нийгмийн тэгш бус байдлыг багасгахын тулд шаталсан татварын бодлого манай улсад оновчтой гэж үзсэн.

Харин тус бодомжтой санал нийлэхгүй буюу прогрессив татварын бодлогыг дэмжихгүй байгаа шалтгаан нь, хувь хүн хичээж, илүү хөдөлмөрлөснийх нь төлөө шийтгэж байгаа мэт өндөр татвар авах нь шударга биш тул хүн бүр ижил хэмжээний татвар төлөх ёстой. Ийнхүү шаталсан татварын бодлого нь иргэдэд ойлгомжгүй байдлыг бий болгодог гэж тайлбарласан.


Эргэлзээтэй, прогрессив бодлогыг дэмжих эсэх нь тодорхойгүй хүмүүсийн тайлбарыг харвал, татвараар бүрдсэн улсын төсвийн үр дүнтэй зарцуулалт, ил тод байдал, авлигад автахгүй байх зэргээс шалтгаална. Хүн бүр татварын хуулийн дагуу цалин, хөдөлмөрийн хөлснөөсөө ХХОАТ-ыг шууд татуулах хэлбэрээр төлдөг тул шатлалын талаар асуух шаардлагагүй гэж хариулсан.

“Хувь хүний орлого өндөр, бага байхаас үл хамааран хүн бүр ижил хувьтай татвар төлөх нь таныхаар шударга уу?” гэсэн асуултын дундаж үнэлгээ 2.5 буюу шударга биш гэж үзэх хандлагатай байна.

Тодруулбал, судалгаанд оролцогчдын 60% буюу ойролцоогоор 10 хүн тутмын 6 нь хувь хүний орлого өндөр, бага байхаас үл хамааран хүн бүр ижил хувьтай татвар төлөх нь шударга биш гэж хариулсан бол 26% буюу ойролцоогоор 4 хүн тутмын нэг нь шударга гэж хариулсан байна.

График 27. Хувь хүний орлого өндөр, бага байхаас үл хамааран хүн бүр ижил хувьтай татвар төлөх нь таныхаар шударга уу?

Дундаж: 2.5




Тайлбар: *Огт шударга биш бол 1, мэдээж шударга бол 5, 1-ээс 5 оноогоор үнэлсэн.*

Хувь хүний орлого өндөр, бага байхаас үл хамааран хүн бүр ижил хувьтай татвар төлөх нь шударга эсэх байр суурийг судалгаанд оролцогчдын хүн ам зүйн үзүүлэлтээр харахад хүйс, орлогын хувьд ($p<0.05$) ялгаатай үр дүн гарсан.

Хувь хүний орлого өндөр, бага байхаас үл хамааран хүн бүр ижил хувьтай татвар төлөх нь шударга гэж үзэх байдал эрэгтэй, 800,000 хүртэлх болон 3,300,000-аас дээш орлоготой хүмүүсийн хүмүүсийн дунд бусадтай харьцуулахад өндөр байна.

Харин тус бодомжийг шударга бус гэж үзэх байдал эмэгтэй, 800,001-1,800,000 төгрөгийн орлоготой хүмүүсийн дунд жин дарж байна.

График 28. Хувь хүний орлого өндөр, бага байхаас үл хамааран хүн бүр ижил хувьтай татвар төлөх нь таныхаар шударга уу? (Хүйс, орлогоор)



Тайлбар: Огт шударга биш бол 1, мэдээж шударга бол 5, 1-ээс 5 оноогоор үнэлсэн.

Хувь хүний орлого өндөр, бага байхаас үл хамааран хүн бүр ижил хувьтай татвар төлөх нь шударга эсэх талаарх байр суурийг ямар шалтгаанаар илэрхийлж буйг фокус бүлгийн ярилцлагаар тодруулсан.

Тус бодомжийг шударга гэж үзэж буй хүмүүс, “орлого ихтэй хүн татварын дарамтад орж, илүү ихийг төлдөг нь бусдаас их хөдөлмөрлөсөн хүнийг шийтгэж байгаа хэлбэр гэж үзэж, хүн бүр тэгш эрхтэй байх хэрэгтэй” гэж тайлбарласан. Иймхүү хүн бүр орлогын хэмжээнээс үл хамааран ижил хэмжээний татвар төлөх нь бүгдэд ойлгоход хялбар байхыг онцолсон.

Харин шударга биш гэж үзэхдээ, иргэдийн амьдралын боломж адил биш тул орлого багатай иргэнд татвар илүү дарамт болдог. Тиймээс өндөр орлоготой хүмүүс нийгмийн өмнө хариуцлага хүлээж илүү хэмжээний татвар төлөх нь оновчтой гэсэн.

ДҮГНЭЛТ

1. Татвар төлөлтийн талаарх байр суурь, нөлөөлөх хүчин зүйлсийн хамаарал

“Хүн бүр татвар төлөх ёстой” гэдгийг хүлээн зөвшөөрөх эсэхийг тодруулахад дундаж үнэлгээ 3.7 (огт хүлээн зөвшөөрөхгүй бол 1, мэдээж хүлээн зөвшөөрөх бол 5) буюу хүн бүр татвар төлөхийг зөв гэж үзэх хандлагатай байна.

Хүн бүр татвар төлөх ёстой гэж үзэх хандлагад нөлөөлөх хүчин зүйлсийг татварын мөнгийг төрийн үйлчилгээнд зарцуулж буйг дэмжих хандлага, бусад хүн татвар төлөхгүй бол өөрөө ч төлөхгүй байж болно гэх нийгмийн орчны нөлөөллийн хандлага, татварын мөнгийг төр үр ашигтай зүйлд зарцуулж буй эсэх талаарх үнэлгээ, прогрессив татварын бодлоготой санал нийлж байгаа эсэхэд регрессийн шинжилгээ хийсэн.

Судалгааны дүнгээр дээрх 4 хүчин зүйл огт нөлөөлөөгүй үед хүн бүр татвар төлөх ёстой гэдэгтэй санал нийлэх байдал 0.459 (огт хүлээн зөвшөөрөхгүй бол 1, мэдээж хүлээн зөвшөөрөх бол 5) байна.

Регрессийн шинжилгээний үр дүнгээс харахад татварын мөнгийг үр ашигтай зарцуулах болон төрийн үйлчилгээ, прогрессив татварыг дэмжих сэдлүүдийг нэмэгдүүлэх нь хүн бүр татвар төлөх ёстой гэх хандлагыг нэмэгдүүлж, бэхжүүлдэг.

Харин зарим хүн төлөхгүй байхад би төлөхгүй байж болно гэсэн сэдэл нь хүн бүр татвар төлөх ёстой гэх хандлагыг бууруулж болох нөлөөтэй байна.

2. ХХОАТ-ын талаарх байр суурь

Судалгаанд оролцогчдын 78% буюу 10 хүн тутмын 8 нь ХХОАТ төлдөг, 15% нь төлдөггүй, 7% нь хааяа төлдөг гэж хариулсан. Боловсрол өндөр, тогтвортой байгууллагад ажилладаг, дундаас дээш орлоготой иргэдийн дунд татвар төлөлт илүү өндөр байна.

ХХОАТ төлдөг хүмүүсийн олонх “хүн бүр татвар төлөх ёстой” гэж үздэг бол татвар төлдөггүй хүмүүс энэ байр суурийг төдийлөн дэмждэггүй байна.

Татвар төлдөг хүмүүсийн 74% нь цалин, хөдөлмөрийн хөлсний орлогоосоо шууд татвар суутгуулдаг бол 24% нь үйл ажиллагааны орлогоо өөрсдөө тайлагнан төлдөг. Шууд суутгал нь голчлон 18–29 насны, төрийн болон хувийн байгууллагад ажилладаг, 1.3–2.8 сая төгрөгийн орлоготой иргэдийн дунд түгээмэл. Харин 30-аас дээш насны, хувийн бизнес эрхэлдэг, 4.8 сая төгрөгөөс дээш орлоготой иргэд орлогоо тайлагнан татвар төлөх нь давамгайлж байна.

Судалгаанд оролцогчдын сарын татвар суутгаагүй дундаж орлого 2,468,705 төгрөг, хамгийн бага нь 150,000, хамгийн өндөр нь 42 сая төгрөг байна. Салбараар авч үзвэл төрийн албан хаагчдын орлого тогтвортой, доод орлого харьцангуй өндөр боловч дээд орлого 4 сая төгрөгөөс дээшгүй. Харин хувийн байгууллагад ажиллагсдын орлого байгууллага, албан тушаал, мэргэжлээс хамаарч ихээхэн хэлбэлздэг. Хувираа бизнес эрхлэгчдийн орлого хамгийн өндөр ч хэлбэлзэл маш өндөр байна.

Шууд суутгуулах хэлбэрээр татвар төлдөг иргэдийн 67% нь төлж буй татварынхаа дүнг мэддэг бол 33% нь мэддэггүй буюу 14% нь буруу мэддэг, 19% нь төлдөг хэмжээнээсээ өндөр гэж боддог байна.

Цалингаас шууд татвар суутгуулах нь татвар төлөхөөс зайлсхийх боломжгүй хэлбэр. Харин орлогоо өөрсдөө тайлагнан ХХОАТ төлдөг иргэд хуулийн үүргээ биелүүлэх, зээлд хамрагдах, бизнесээ өргөжүүлэх, төрийн үйлчилгээ авах зэрэг шалтгаанаар татвар төлдөг.

Харин хувиараа бизнес эрхлэгчдийн дунд бүх зардал хувь хүнд ногддог гэх үндэслэлээр ХХОАТ төлдөггүй тохиолдол байдаг аж.

3. Төр ба иргэний татварын харилцан тохиролцоо

Судалгаанд оролцогчдын 68%, өөрөөр хэлбэл 10 хүн тутмын 7 нь татварын орлогоор төрийн үйлчилгээ санхүүжих ёстой гэж үзсэн нь төр ба иргэний хоорондын нийгмийн гэрээг хүлээн зөвшөөрч буйг харуулж байна. Тэд татварыг төрийн үйлчилгээний гол санхүүжилтийн эх үүсвэр гэж үздэг хэдий ч төрийн ил тод байдал, хариуцлага, мөн халамжийг зөвхөн зорилтот бүлэгт чиглүүлэх шаардлагыг давхар тэмдэглэсэн.

Харин багахан хэсэг нь татварын тогтолцоог шүүмжилж, үүний шалтгаанаар халамжийн хавтгайрсан бодлого, төсвийн үр ашиггүй зарцуулалт, татварын өндөр дарамт болон төрийн үйлчилгээний чанарын сул байдал зэрэг асуудлыг дурдсан байна.

4. Төр ба татвар, үйлчилгээний солилцоо

Иргэдийн хувьд “татвар төлснөөр чанартай үйлчилгээ авна” гэсэн хүлээлт байдаг ч судалгаанд оролцогчдын дундаж үнэлгээ 1.7 (маш муу бол 1, маш сайн бол 5) гарсан нь төр татварын орлогыг шударгаар, иргэдэд хэрэгтэй чиглэлд зарцуулж чаддаггүй гэж үзэж байгааг харуулж байна.

Мөн ХХОАТ-ын тухай хуулийн 21.1-т заасан татварын хувь, хэмжээний талаарх иргэдийн үнэлгээ 1.8 бөгөөд энэ нь татварын дарамт өндөр гэж үзэх хандлага давамгай байгааг илтгэнэ. Ийнхүү татвар өндөр гэж үнэлэх байдал нь 25–49 насны, 3.8 сая төгрөгөөс дээш орлоготой хүмүүст илүү ажиглагдсан бөгөөд орлого нэмэгдэхийн хэрээр ХХОАТ-ыг өндөр гэж үзэх хандлага эерэг хамааралтайгаар өсдөг байна.

Татварыг өндөр гэж үздэг ч иргэдийн олонх нь татвар бууруулах бодлогыг дэмжээгүй. Учир нь татвар бууруулах нь төрийн үйлчилгээний хүртээмж, чанарыг хязгаарлах, эсвэл төрийн үйлчилгээг мөнгөөр худалдаж авах шаардлагатай болгоно гэж тэд үзсэн. Төрийн үйлчилгээний оронд хувьдаа төлбөр төлөхөд бэлэн бус хүмүүс нь голдуу 50-иас дээш насныхан, бүрэн дунд болон түүнээс доош боловсролтой, 2.3 сая төгрөгөөс доош орлоготой иргэд байсан бөгөөд эдгээр бүлэг төрийн үйлчилгээний зардлыг хувиараа даах боломжгүй гэдгээ илэрхийлсэн байна.

Монгол Улсын хөгжлийг дэлхийн жишигт хүргэхийн тулд татвар нэмэгдүүлэхийг зөвшөөрөх эсэхийг асуухад оролцогчдын 79% нь татгалзсан. Тэдний үзэж буйгаар улсын төсвийн зарцуулалт үр ашиггүй, үрэлгэн, хариуцлагагүй, ил тод бус, иргэдийн орлого амьжиргаанд нь хүрэлцдэггүй, түүнчлэн авлигын асуудал шийдэгдээгүй байгаа нөхцөлд татвар нэмэх нь шударга бус гэж үзжээ.

5. Бусдын хандлага татвар төлөх байдалд нөлөөлөх нь

Хүмүүс бусдын зан үйлийг ажиглаж, олонхын санал бодлыг дагах хандлагатай. Нийт иргэдийн дийлэнх нь татвараа төлдөг бол хүмүүс үүнийг зөв гэж үзэн татвар төлөх зан үйл нэмэгддэг. “Зарим хүн татвар төлөхгүй байгаа тул би татвар төлөхгүй байсан нь дээр” гэсэн үзэлд санал нийлэх байдлын дундаж үнэлгээ 1.8 (огт санал нийлэхгүй бол 1, мэдээж санал нийлэх бол 5) буюу санал нийлэхгүй талдаа байна. Санал нийлэхгүй байгаа шалтгаан нь татвар төлөх нь ёс суртахуун, хариуцлага гэж үздэг, мөн татварын мөнгө шаардлагатай үйлчилгээнд зарцуулагддаг гэдгийг мэддэгтэй холбоотой. Харин бусдыг дуурайж татвар төлөхгүй байх нь татвар төлөлтийн тэгш бус, шударга бус байдал, татварын зарцуулалт дахь итгэл алдалт, татварын хяналт сул байгаатай холбоотой гэж үзжээ.

Судалгаанд оролцогчдын 62% буюу 10 хүн тутмын 6 нь эргэн тойронд ХХОАТ төлдөггүй хүн байдаг гэж, харин 10 хүн тутмын 4 нь тийм хүн байдаггүй гэж хариулсан. Эргэн тойронд татвар төлдөггүй хүн байна гэж харсан иргэдийн үзэж буйгаар энэ нь “Монголд татвар төлж ч болдог, төлөхгүй ч байж болдог” гэсэн буруу ойлголтыг нийгэмд бий болгож байна. Мөн Татварын Ерөнхий газарт татвар төлөгчдийн мэдээлэл бүрэн бус, малчид, өндөр орлоготой хувиараа бизнес эрхлэгчид, орлого багатай иргэд татвар төлдөггүй тохиолдол түгээмэл гэж дурдсан.

Зарим хүн татвар төлдөггүй шалтгаан нь ажилгүйдэл, албан бус хөдөлмөр эрхлэлт, тогтмол бус орлого, орлогын хүрэлцээгүй байдал, амьжиргааны түвшин доогуур зэрэг эдийн засгийн хүчин зүйлтэй холбоотой гэж иргэд үзсэн. Түүнчлэн татварын мөнгөний үр ашиггүй зарцуулалт, татварын бодлогын шударга бус, ил тод бус байдал, хяналт сул зэрэг татварын системийн асуудал, мөн иргэдийн татварын талаарх мэдээлэл, ойлголт дутмаг, хувь хүний хандлага, итгэл үнэмшил сул байдал нөлөөлж байгааг онцолсон.

6. Прогрессив татварыг хүлээн зөвшөөрөх байдал

Прогрессив буюу шаталсан татварын бодлого нь бага орлоготой иргэдэд үзүүлэх дарамтыг бууруулж, нийгмийн тэгш бус байдлыг багасгахад чиглэдэг. Монгол Улсад орлогын түвшнээс хамаарсан шаталсан татварын тогтолцоо хэрэгждэг бөгөөд судалгаанд оролцогчид энэ бодлогыг хэрхэн хүлээн авч буйг үнэлэхэд дундаж үнэлгээ 3.1 (огт дэмжихгүй бол 1, мэдээж дэмжих бол 5), өөрөөр хэлбэл дэмжих хандлага давамгай гарсан.

Прогрессив татварыг дэмждэг хүмүүс голчлон 40-өөс дээш насны, эмэгтэй, бага эсвэл тусгай дунд боловсролтой, төрийн албанд ажилладаг, мөн 800,000–1,800,000 болон 3.8–4.3 сая төгрөгийн орлоготой иргэд байна. Тэдний хувьд өндөр орлоготой хүмүүс нийгмийн баялгаас илүүг хүртдэг, илүү боломж, дэмжлэг авдаг учраас нийгмийн өмнө илүү хариуцлага хүлээж, илүү өндөр хувьтай татвар төлөх ёстой гэж үзжээ. Мөн шаталсан татварын бодлого нь нийгмийн тэгш бус байдлыг бууруулах хамгийн шударга арга гэж тайлбарласан.

Харин прогрессив татварыг дэмждэггүй хүмүүс нь ихэвчлэн 18–39 настай, эрэгтэй, бүрэн дунд болон дээд боловсролтой, хувийн байгууллагад ажилладаг эсвэл хувиараа бизнес эрхэлдэг, мөн 4.3 сая төгрөгөөс дээш орлоготой иргэд байна. Тэдний үзэж буйгаар, илүү хөдөлмөрлөж, илүү орлого олдог хүнийг өндөр хувьтай татвар авах замаар “шийтгэж” болохгүй бөгөөд хүн бүр ижил хувьтай татвар төлөх нь шударга гэжээ. Мөн шаталсан татварын тогтолцоо иргэдэд ойлгомжгүй, төвөгтэй байдлыг үүсгэдэг гэж үзсэн.

“Хүн бүр ижил хувьтай татвар төлөх нь шударга уу?” гэсэн асуултад дундаж үнэлгээ 2.5 (огт шударга биш бол 1, маш шударга бол 5) гарч, олонх иргэд ижил хувьтай татварын тогтолцоог шударга бус гэж дүгнэжээ. Судалгаанд оролцогчдын 60% нь орлого багатай хүмүүс ижил хувьтай татварын нөхцөлд илүү дарамтад ордог тул шаталсан татвар илүү оновчтой гэж үзсэн бол 26% нь шударга гэж хариулсан. Ижил хувьтай татварыг шударга гэж үзэх хандлага эрэгтэй, 800,000 төгрөгөөс доош болон 3.3 сая төгрөгөөс дээш орлоготой бүлэгт харьцангуй өндөр гарсан. Харин шударга бус гэж үзэх хандлага эмэгтэй, 800,001–1,800,000 төгрөгийн орлоготой иргэдийн дунд давамгайлжээ.

Ижил хувьтай татварын бодлогыг дэмжигчид хүн бүр тэгш эрхтэй, татварын систем ойлгоход хялбар байх ёстой гэж үзсэн. Харин эсрэг байр суурьтай иргэдийн тайлбарлахдаа иргэдийн амьжиргааны боломж ижил бус тул орлого багатай иргэнд нэг ижил хувьтай татвар илүү хүнд дарамт үүсгэдэг, харин өндөр орлоготой хүмүүс нийгмийн өмнө илүү хариуцлага хүлээх нь шударга гэж тодорхойлжээ.

САНАЛ

Дээрх дүгнэлтэд үндэслэн дараах саналыг хүргүүлж байна.

- Татварын мөнгөний зарцуулалтын ил тод байдлыг нэмэгдүүлэх: Татварын орлого, зарцуулалтын тайланг төрийн үйлчилгээний салбар, төсөл, аймаг, дүүргээр тогтмол, ойлгомжтой хэлбэрээр иргэдэд хүргэдэг байх;
- Эрүүл мэнд, боловсрол, зам, халамж гэх мэт төрийн үйлчилгээний чанар ба хүртээмжийг сайжруулж, иргэдийн татвар төлөх идэвх санаачилгыг дэмжих;
- Төсвийн зарцуулалтын авлигын эрсдэлийн үнэлгээг тогтмол хийх, ил тод тайлагнах.
- Татвар төлөлтийн үр ашигт бусадтай харьцуулахад бага ач холбогдол өгч буй залуучууд буюу анхлан татвар төлөгчдөд татварын орлого болон төрийн үйлчилгээний зарцуулалтын ач холбогдлыг таниулах;
- Татвар төлдөг олонхын жишгийг түлхүү харуулсан мэдээллийг олон нийтэд хүргэх.
- Шаталсан татварын зорилго, үндэслэл, нийгмийн тэгш бус байдлыг бууруулах ач холбогдлыг иргэд, олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр хүргэх;
- Ижил хувьтай татварын үр дагаврыг (бага орлоготой иргэдэд үүсэх дарамт) бодит жишээгээр тайлбарлаж, хүргэх;
- Орлогын тайлагналын хяналтыг сайжруулж, өндөр орлоготой бүлгийн татварын биелэлтэд анхаарах;
- Албан бус хөдөлмөр эрхлэгч, малчид, хувиараа бизнес эрхлэгчид болон өндөр орлоготой бүлгийн татвар төлөлтийн бүртгэлийн системийг боловсронгуй болгож, хяналтыг сайжруулах;
- Татварын дарамтын бууруулах: Эмзэг бүлэг, бага орлоготой иргэдийг ХХОАТ-аас чөлөөлж, хөнгөлөлт үзүүлэх шинэ хэлбэрүүд боловсруулах;
- Орлогоо тогтмол тайлагнах боломжгүй бүлгүүдэд зориулсан сургалт, зөвлөмж, гарын авлагыг олон нийтийн төвүүдээр дамжуулан хүргэх.

НОМ ЗҮЙ

Adams, J. S. (1965). Inequity In Social Exchange. *Advances in Experimental Social Psychology Volume 2*, 267-299.

Bennett, J. (2017). *Jean-Jacques Rousseau: The Social Contact.*

Cialdini, R. B. (2004). *Social influence: Compliance and conformity. .* Annual Review of Psychology.

Feld, F. (2007). *Tax compliance is the result of a psychological tax contract based on reciprocity between taxpayers and the state.*

Fishbein, M. &. (2010). *Predicting and changing behavior: The reasoned action approach. .* New York: Psychology Press.

Frey& Torgler. (2007). *Taxpayers are conditionally cooperative — they comply as long as they perceive others and the state as cooperative and fair.*

Mirrlees, J. A. (1971). An Exploration in the Theory of Optimum Income Taxation. *The Review of Economic Studies, Volume 38, Issue 2*, 175–208.

Wenzel, M. (2005). *Motivation or rationalisation? Causal relations between ethics, norms and tax compliance.* Journal of Economic Psychology, 26(4), 491–508.

П.Одгэрэл. (2025). *Татварын эрх зүйн ерөнхий анги /Захиргааны ерөнхий хууль ба Татварын ерөнхий хууль.* УБ.

Үндэсний статистикийн хороо. (2024). Ажиллах хүчний судалгаа. *2024 оны III улирлын тайлан*.